

МОНГОЛИАН ECONOMY


2015 оны 12 сар. № 22 (101)

www.mongolianeconomy.mn

ЭДИЙН ЗАСАГ
Макро хөшүүрэг

БИЗНЕС
Хямрал дагасан хямдрал

ЕРТӨНЦ
Уур амьсгалын өөрчлөлтийн “эргэх цэг”



Ц.Балдорж:

Тогтолцоог нь өөрчлөхөөс наана хэн ч юу ч улс төрийн бохир байдлыг засаж чадахгүй

2016

ШИНЭ ЖИЛИЙН МЭНД ХҮРГЭЭ!

Цас бударч өнгө нэмэх
Нас нэмж ухаан тэлэх
Хувьцаа есч хөрөнгө бялхах
Хүчтэй байж хамтдаа хөгжих
Угтан золгож буй шинэ он маань
Үндэстэн бидний амжилтын жил байх болтугай!

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ҮНДЭСТЭН

ARD ДААТГАЛ
КОМПАНИ

Ердийн даатгал

ARD КРЕДИТ
ББСБ

Банк бус санхүүгийн
байгууллага

ARD АКТИВ
ХЗХ

Хадгаламж зээлийн
хоршоо

WILD

Вэб сайт, маркетинг,
брендинг хөгжүүлэлт

TENGER
SYSTEMS

Санхүүгийн програм
хангамж

IET Техник Технологийн
Дээд сургууль

Техникийн дээд
боловсрол, Коосэн
сургууль

ARD АКТИВ
ХЗХ

Брокер, дилер, андеррайтер,
хөрөнгө оруулалтын зөвлөх

Nomyu Hishig

Үл хөдлөх хөрөнгийн
түрээс

ПЯНЗНЫ ЭРИН ҮЕ ЭРГЭН ИРЖ БАЙНА

Хөгжмийн ертөнцөд iTunes болон бусад streaming сайтууд Spotify, Napster, Pandora ноёрхож байна. Гэхдээ iTunes – ээр дамжуулж дижитал хөгжмийг борлуулах бизнесийг санаачлагч алдарт Стив Жобс өөрөө гэртээ аналог хөгжим сонсдог байсныг та мэдэх үү? Амьд аналог дуугаралтыг мэдрүүлж чадах пянзны худалдан авалт сонирхолтойгоор буцаж “мода”-нд орж байна. Дижитал хөгжмийн борлуулалт буурч байгаа өнөө үед пянзны борлуулалт 50% өсч байгааг Newsweek.com дээр мэдээллэжээ. Мэдээж хөгжмийн энэ форматыг шүтэн бишрэгчид маш олон байдаг. Гэхдээ хамгийн чанартай хөгжмийн дугаралтыг пянзны л гадаргуу дээр буулган насан туршдаа сонсож, хэдэн үе дамжуулан хадгалж болдог гэдгийг хэрэглэгчид ихэд анхаарах болжээ. Тийм учраас гадны томоохон хамтлагууд эргэж пянзан дээр дуугаа бичүүлэх хандлага ч нэмэгдэж байна. Тиймдээ ч 2015 оны хамгийн их борлуулагдсан пянзны жагсаалтанд Sam Smith, Ed Sheeran нарын альбомууд бичигдсэнийг харж болно. Хөгжмийн ертөнцийн бичлэгийн формат дахь хувьсал өөрчлөлтийн үед хамгийн тогтвортой байж одоо ч үнэ цэнээ алдаагүйгээр барахгүй одоо улам дэлгэрч сэргэж байгаа төрөл бол яах аргагүй пянз бичлэг. Энэ нь дуугаралтын хувьд хамгийн үнэн зөв, цэвэр гаргалгаа болох аналогий төрөлтэй нь шууд хамааралтай. Хадгалалтын хувьд ч нөхцлийг нь зөв хангавал 100-аас ч дээш жил хадгалж болох нь батлагдсан байдаг.



НЭГ ДУГААР 15,000₮
УЛИРАЛ /6 ДУГААР/ 90,000₮
ХАГАС ЖИЛ /12 ДУГААР/ 180,000₮
ЖИЛ /24 ДУГААР/ 360,000₮

18,000₮

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ЭРХЛЭГЧ:

Д.БЭХБАЯР / 9999-4248

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ:

И.ОТГОНЖАРГАЛ / 8800-6228

СЭТГҮҮЛИЙН РЕДАКТОР:

Б.ҮҮРИЙНТУЯА

АНГЛИ ХЭЛНИЙ РЕДАКТОР:

О.ТҮВШИН

ОРЧУУЛАГЧ:

Б.ЭНХМӨНХ

ВЭБ РЕДАКТОР:

Б.ЭНХЦЭЦЭГ

СЭТГҮҮЛЧИД:

Г.ОРХОН

Ц.ЭЛБЭГСАЙХАН

ДИЗАЙНЕР:

Б.СЭР-ОД

МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР:

Д.БАРИАНЖАВ / 9409 2904/

Э.ЗОРИГТ /9409 2905/

ХАЯГ

Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг.

I хороо, Энхтайвны өргөн чөлөө.

Экспресс тауэр. 1101 тоот

15160 Улаанбаатар, Төв шуудан,

ш/ х-2762

WWW.MONGOLIANECONOMY.MN

INFO@MONGOLIANECONOMY.MN

Утас/Факс: 976 - 7011 5476

"Улаанбаатар принт" ХХК-д хэвлэв

WWW.UBPRINT.MN

БОРЛУУЛАХ ЦЭГҮҮД:

"Интер ном"

"Цэцэг төв"

"Минж плаза"

"Алтантүлхүүр" номын дэлгүүр

"Номин" супермаркетин бүх салбар

"Макс" супермаркетин бүх салбар

"Фреско" супермаркет

BTSI супермаркет

"Аз орчлон" номын дэлгүүр

"Билэ" их дэлгүүрийн номын тасаг

"Гранд Плаза" дахь супермаркет

"Мир" номын дэлгүүрийн

"GRAND PLAZA"

"METRO MALL"

"SKY" супермаркет

"Улаанбаатар" их дэлгүүр

"Мах mall" дэх салбарууд



ГҮНЗГИЙ МЭД



“ P16



Далайн түвшнээс доош 135 метрт иржээ. Биднийг гүний уурхайд нэвтрэхээс өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч, осол аваар болох, агааргүйдэхэд хэрэглэх хүчилтөрөгчийн сав зүүж өгч, онцгой тохиолдолд хорогдох байранд хүргэж өгөх хэдэн хөтөч дагалдан яваа юм.

Гадаа өдөртөө -26 хэм хүртэл хүйтэрч байхад газар доор биднийг +25 хэмийн дулаан орчин угтав.

ЭДИЙН ЗАСАГ

- 11 Ц.Балдорж: Авилгачдын хүрээнд орж нэрээ бузарлахгүйн тулд улс төрд орох бодлоо орхисон
- 13 Холын зорилго үгүй бол ойрын зовлон оршино
- 16 Хөгжлийн гүнээс
- 18 Макро хөшүүрэг
- 19 Эгийн голын шинэ түүх
- 21 Шинэ санаачилгатай өмч хувьчлал
- 23 Сүүдрээс урьтаж
- 25 Шчоошиг

БИЗНЕС

- 28 Хямрал дагасан хямдрал
- 30 Шинэ жилийн ширээ ямар байх бол
- 32 Төрийн үйлчилгээнд онлайн банк нэвтэрлээ

ЕРТӨНЦ

- 34 Уур амьсгалын өөрчлөлтийн “эргэх цэг”
- 36 Шинжааны хүчирхийлэл: Хятад улсад терроризмын асуудал бий юу

“ P34



Талуудын 21-р чуулганд 195 орны Засгийн газрын төлөөлөл, иргэний нийгэм, хувийн хэвшил, хэвлэлийн төлөөлөгч зэрэг нийт 50 мянга орчим төлөөлөгч оролцсон юм.

“ P30



Хямрал болохоор махны хэрэглээ нэмэгддэг гэдэг. Гэвч худалдан авалт муу байгааг махны худалдаачид хэлж байна. Энэ нь тус таваарын нийлүүлэлт нэмэгдсэнтэй холбоотой байж болох.

ТАНИЛЦУУЛГА

Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан “Сэрэлт” ХХК нь “Сэрэлттакс ТМЗ” ХХК-ийг үүсгэн байгуулж Сангийн сайдын 2015 оны хоёрдугаар сарын 16-ны өдрийн 37 тоот тушаалын тусгай зөвшөөрөлтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Харилцагчиддаа татвараа хуулийн дагуу үнэн зөв тодорхойлоход нь туслах үндсэн үүрэгтэй манай хамт олон татварын эрх зүйн орчныг тасралтгүй судалж шинжлэн, харилцагчдынхаа үйл ажиллагаанд учирч болох татварын аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх, татварын эрсдэлгүй ажиллуулах үндсэн зорилт тавин ажиллаж байна.

Бид харилцагчдаа шаардлагатай мэдээлэл, зөвлөмжөөр цаг тухайд нь бүрэн хангах, аливаа эрсдлийг богино хугацаанд арилгах, заавар зөвлөмжийг хууль тогтоомжын хүрээнд хамгийн энгийн ойлгомжтой хувилбараар хүргэхийг зорьж, татварын хуулиудын өөрчлөлт, шинэчлэлүүдийг анхааралтай судалж мэдээллэн ажиллаж байна.

- Нягтлан бодох бүртгэлийн аутсорсинг үйлчилгээ
- Татварын зөвлөх үйлчилгээ
- Бусад зөвлөх үйлчилгээ

Хаяг: Чингэлтэй дүүрэг 1-р хороо
Энхтайваны гудамж, Denver оффис, 304 тоот
Утас/Факс: 99093541, 88002321

Дэлхийн эдийн засгийн замын зураг
бүтэн жилийн турш тантай хамт

Дэлхий 2016

Дэлхий нийтийн ирээдүйн таамаг

The Economist Таны ирэх
жилийн хөтөч

The Economist сэтгүүлийн
“THE WORLD IN 2016” жилийн
дугаарыг Монгол дахь албан ёсны тусгай
зөвшөөрөл эзэмшигч **“Mongolian Economy”**
сэтгүүл монгол хэлээр эрхлэн гаргах гэж
байна.

2016.01 сард танд хүрнэ



Утас 94092904, 94092905, 70115476, 70115477
www.marketing@mongolianeconomy.mn
www.info@mongolianeconomy.mn



МОНГОЛД

АЖ ҮЙЛДВЭР

Манай улс Бүгд Найрамдах Чех улстай хамтран 300 мянган тоннын хүчин чадалтай коксын үйлдвэр барихаар болжээ. Уг хамтын ажиллагааны санамж бичгийг Аж үйлдвэрийн сайдын өнгөрсөн сард Бүгд Найрамдах Чех улсад хийсэн айлчлалын үеэр талууд үзэглэв. Тус төсөлд нийт 160 сая еврогийн санхүүжилт шаардлагатай бөгөөд үүний 70 хувьд Чехийн талаас



хөрөнгө оруулахаар болж. Коксын үйлдвэр нь хоёр жилийн хугацаанд баригдах бөгөөд яамны зүгээс ирэх онд үйлдвэрийн барилгын ажлыг эхлүүлэхээр төлөвлөж байгаа юм байна.

ҮЛ ХӨДЛӨХ

Энэ сарын 4-ний байдлаар өмнө нь орон сууцны ипотекийн зээл авсан зээлдэгчдээс 837.8 тэрбум төгрөгийн зээлийг найман хувийн хүүтэй зээлийн эх үүсвэрээр дахин санхүүжүүлэх хүсэлт арилжааны банкуудад иржээ. Үүнээс банкууд 19413 зээлдэгчийн нийт 581 тэрбум төгрөгийн ипотекийн




зээлийг дахин санхүүжүүлж, найман хувийн хүүтэй ипотекийн зээл рүү шилжүүлсэн байна. Мөн банкууд 41055 иргэнд 2.2 их наяд төгрөгийн орон сууцны ипотекийн зээл шинээр олгохоор шийдвэрлэжээ.

ТАТВАР

Ирэх онд НӨАТ-ын цаасан


падааныг цахим хэлбэрт шилжүүлэх аж. Тодруулбал, шинэ оны эхний өдрөөс татварын албан ёсны төлбөрийн баримт хэвлэх ebarimt.mn цахим хуудсыг ажиллуулж эхлэх гэнэ. Тус цахим хуудас нь төлбөрийн анхан шатны баримт хэвлэх бөгөөд худалдаа үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж болон иргэдэд төлбөрийн баримт өгөх, уг баримтын мэдээлэл дээр үндэслэн одоо хэрэглэгдэж буй НӨАТ-ын цаасан падааныг цахим хэлбэрт



шилжүүлэх ажлын эхлэл аж. Шинэчлэн баталсан Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль ирэх сарын 1-нээс хэрэгжиж эхлэх бөгөөд татварын системийг боловсронгуй болгох, далд эдийн засгийг хумихад иргэн бүрийн оролцоог нэмэгдүүлэх, төлсөн НӨАТ-ын 20 хувийг буцаан олгох зэрэг боломжыг төрөөс бий болгож өгч байгаа юм.

САНХҮҮ

Арилжааны банкуудын актив энэ оны гуравдугаар улирлын байдлаар 21.3 их наяд төгрөг болж, өмнөх улирлаас 2.4 хувь буурч, өнгөрсөн



оны мөн үеэс 1.7 хувиар өсчээ. Тус салбарын активын өсөлт өнгөрсөн оны эхний улирлаас эхлэн саарч улирлын өөрчлөлтийн хувь дунджаар таван хувьтай болж тогтворжиж эхэлжээ. Энэ нь эдийн засгийн өсөлт саарч банкуудын зээл олголтын дүн хумигдсантай холбоотой хэмээн Монголын банкны холбооныхон үзэж

байна.

УУЛ УУРХАЙ

Стратегийн ач холбогдол бүхий Шивээ-Овоогийн нүүрсний ордыг түшиглэн эрчим хүчний томоохон цогцолбор барих төслийг Монгол Улс урд хөрштэй хамтран хэрэгжүүлэхээр ажиллаж байгаа аж. Төслийн хүрээнд 34 сая тонн нүүрсийг жил бүр тогтмол тасралтгүй нийлүүлэх үүргийг Монголын тал хүлээж буй. Тиймээс тус



орд газарт тусгай зөвшөөрөл эзэмшигч “Эрдэнэс Монгол” болон “Шивээ Овоо” ХХК-иуд хэлэлцээ хийж, тохирсон тохиолдолд дээрх үүргийг хэрэгжүүлэх хамтарсан аж ахуйн нэгжийг энэ онд багтаан байгуулах шийдвэрийг Засгийн газрын хуралдаанаар гаргав.

ХУДАЛДАА

Улсын гадаад худалдааны эргэлт өнгөрсөн сарын эцэст 7735.5 сая ам.долларт хүч, өнгөрсөн оны мөн үеэс 22.8 хувиар буурчээ. Үүнд экспорт 947.5 сая ам.доллараар, импорт 1337.5 сая ам.доллараар тус тус буурсан нь нөлөөлсөн.



Нийт бараа эргэлтийн 62.4 хувийг урд хөрштэй, 13 хувийг хойд хөрштэй тус тус хийжээ. БНХАУ-тай хийсэн худалдаа өнгөрсөн оны мөн үеэс 21.9 хувиар, ОХУ-ынх 32.5 хувиар тус тус буурсан дүнтэй гарсан байна. ■

НЭГ ХҮҮХДИЙН БОДЛОГО



Хятадын засгийн газар нэг хүүхдийн бодлогоо халж оронд нь хоёр хүүхдийн бодлогыг дагана гэж аравдугаар сард мэдэгдсэн билээ. Ингэснээр нэг хүүхдийн бодлогыг зөрчиж төрсөн олон сая бичиг баримтгүй иргэд "Хукоу" гэх шаардлагатай бичиг баримтаа авах бололцоотой болох аж. Тус улсын нийт хүн амын нэг хувь буюу ойролцоогоор 13 сая хүн сургуульд суралцах, албан ёсны ажилд орох, мөн эрүүл мэндийн үйлчилгээ авах зэрэгт шаардлагатай бичиг баримтгүй байдаг гэжээ. Нэг хүүхдийн бодлогыг зөрчиж төрсөн хүүхдэд хукоуг авах боломж байдаг ч ингэхийн тулд торгууль ноогдуулдаг учир дийлэнх өрхүүд санхүүгийн бололцоогүй байдаг бөгөөд тэднээс гадна сая сая өнчин хүүхэд бичиг баримтгүй амьдарч иржээ.

ОПЕК-ИЙН УУЛЗАЛТЫН ҮР ДҮН



ОПЕК-ийн гишүүн орнуудын төлөөлөгчид өөрсдийн дараагийн алхмуудыг хэлэлцэхийн тулд арванхоёрдугаар сарын 4-нд Вена хотноо цуглацгаажээ. Иран улс тэдэнд хориг арга хэмжээ авч эхэлснээс өмнөх үетэй адил үйлдвэрлэлтийн хэмжээнд хүрэхээс нааш газрын тосны үйлдвэрлэлийн хязгаарлалтын талаар авч хэлэлцэх хүсэлгүй байгааг мэдэгдсэний улмаас гишүүн орнууд хязгаар тавих асуудлын талаар

шийдэлд хүрч чадсангүй. Уг мэдэгдлийн улмаас зах зээл дээр үнийн хямдрал болж нэг баррель газрын тосны үнэ 40 ам.доллараас доош ортлоо бууржээ. Хамгийн сүүлд 2009 оны эхээр буюу Их Хямралын үед газрын тосны үнэ үүнтэй адил доогуур түвшинд хүрч байжээ. ОПЕК-ийн Ерөнхий нарийн бичгийн дарга Абдулла Аль-Бадри хэлэхдээ нийлүүлэлтээр хахаж цацаж байгаа энэ үед Иран хэр их газрын тос нийлүүлхийг мэдэхгүй байна гэжээ. Харин "Goldman Sachs" групп нэг баррель газрын тосны үнэ 20 ам.доллараас ч буурч магадгүй хэмээн үзэж байгаа аж. Нэг жилийн өмнөх хурлын үеэр Саудын Араб үйлдвэрлэлийг бууруулахыг эсэргүүцэж үүний оронд зах зээлд эзлэх хувиа хамгаалж АНУ зэрэг өндөр өртөгтэй үйлдвэрлэгчдийг зах зээлээс шахах хэрэгтэй гэж байсан юм. Наад зах нь богино эсвэл дунд хугацаанд газрын тосны үнэ доогуур байх төлөвтэй байгаа бөгөөд зарим ОПЕК-ийн гишүүд хурлын үр дүнд сэтгэл хангалуун бус байгаа аж.

ХҮҮГИЙН ТҮВШИНГЭЭ ТОГТВОРТОЙ БАРЬЖ БАЙНА



Европын төв банк мөнгөний нийлүүлэлтийг нэмэхгүй байх шийдвэрийг олонхийн саналаар шийдлээ. ЕТБ-ны хөтөлбөрөөр шинэ бондуудыг үргэлжлүүлэн худалдан авч өмнө авсан хуучин бонд нь өсч хэдэн зуун тэрбум еврог бий болгоно гэж тэмдэглэжээ. Бонд үргэлжлүүлэн худалдан авах шийдвэрээр бондын худалдан авалт 2017 оноос эхлэн хоёр жилийн турш үргэлжлэх аваас 320 тэрбум евро зарцуулагдах болно хэмээ Люксембургийн Төв банкны захирал Ив Мэрш хэлэв. Захирлуудын зөвлөлийн уг шийдвэрт хүрэх болсон нэг шалтгаан нь тэд АНУ-ын Төв банкыг дараагийн хурлаараа бодлогын хүүгээ нэмнэ гэж таамаглаж байгаатай

холбоотой. АНУ-ын бодлогын хүү өссөнөөр Евро бүсийн аж ахуйн нэгжүүд болон өрхүүдэд хөрөнгө оруулалтын санхүүжилт хийхэд илүү үнэтэй тусах бөгөөд энэ нь Европын Холбооны сэргэх оролдлого болон ЕТБ-ийн хүүгийн түвшингээ барих зорилгод саад учруулах магадлалтай юм. ЕТБ саяхан хадгаламжийн хүүгээ 0.10 хувиар бууруулж одоо байгаа хасах 0.30 хувьд хүргэсэн нь банкууд төв банкинд мөнгөө хадгалуулхын тулд илүү ихийг төлөх шаардлагатай болж байна гэсэн үг. Санхүүгийн ертөнцийнхөн ЕТБ-ны мөнгөний нийлүүлэлтийг үл нэмж хувьцаагаа зарж еврог буцаан худалдаж авах шийдвэрийг таашаахгүй байгаа аж.

ТАВААР



Нийлүүлэлтийн хэтрэлт газрын тосны үнэнд нөлөөлөөд зогсохгүй төмрийн хүдрийн үнэнд нөлөөлж байна. Арванхоёрдугаар сарын 9-нд нэг тонн төмрийн хүдрийн үнэ 40 ам.доллараас доош унасан нь арваад жил болоогүй үзэгдэл боллоо. Тухайн өдөр олон улсын уул уурхайн компани болох "Anglo-American" 85 мянган ажлын байр буюу нийт ажилчдынхаа бараг гуравны хоёрыг цомхотгох болсноо зарласан юм. Тус компанийн бизнес 60 хувиар агшиж, мөн ногдол ашиг нь 2016 он хүртэл зогсох аж. Дотоодын зах зээлийн нөхцөл байдлын улмаас Хятадын компаниуд анх удаа 100 сая тонноос илүү ган экспортлож, тэр ч байтугай зарим үйлдвэрлэгчид өөрсдийн нөөцөө алдагталтайгаар зарж байна. Төмрийн хүдрийн доогуур үнэ зарим жижиг үйлдвэрлэгчдийг хүнд байдалд оруулах магадлалтай байна, жишээ нь Австралийн "BC Iron" компани уг үнийн уналтаас шалтгаалан өөрсдийн баруун Австрали дахь төслийг зогсоосон аж. ■

*Монголын улс төр улс төр биш
боллоо. Тэдний амин хувиа хичээсэн
бодлогын үр дүнд эдийн засаг
хямарч, унаж, элгээрээ хэвтлээ.
Бизнес зогсож, иргэд мөнгөгүй
боллоо. Энэ бүхэн Монголын улс
төрийн, улс төрийн намуудын,
улстөрчдийн хийсэн “гавьяа”.*

“Mongolian Economy” сэтгүүл

Ц.Балдорж: Авлигачдын хүрээнд орж нэрээ бузарлахгүйн тулд улс төрд орох бодлоо орхисон

“Өнөөдөр” сонины үүсгэн байгуулагч, “Монгол нь юс” группийн ерөнхий захирал агсан, нэрт сэтгүүлч Ц.Балдорж эрхлэгчийнхээ зургаар сэтгүүлээ гоёлоо. Учир нь, энэ өдрүүдэд Бал эрхлэгчийн маань бурхны оронд одсон цаг үе нь таарч буй. Үүнтэй холбоотойгоор “Балдорж сан”, Монголын сэтгүүлчдийн эвлэл хамтран онол практикийн бага хурал хийжээ.

Харин манай сэтгүүл улс төрийн өнөөгийн байдалтай холбоотойгоор, улстөрчдийг санаж сэрээсэй гэсэн үүднээс түүний найман жилийн өмнөх ярилцлагыг зохиогчийн зөвшөөрөлтэй товчлон хүргэж байна. Хэдийгээр 2007 оны ярилцлага ч гол утга санаа нь өнөөдрийн, яг одооны манай улс төрийн байдлыг, улстөрчдийг онож хэлсэн учраас цаг хугацаа урсан өнгөрөх тусам үнэ цэнэтэй санагдах. Найман жилийн өмнөх улс төрийн байдал өнөөдөр бахь байдгаараа. Улам хурцдан улам бугшсан, улам хагаралдаж муудалцсан, улам шунасан, улам баяжсан, улам авлигажсан, улам хардсан сэрдсэн, улам хувиа хичээх болсоор байгаа энэ үед түүний үнэн үг нэгийг бодуулж хоёрыг ухааруулах биз ээ.



Фотог Ц.Батбаттар

М.Уранчимэг

-Сүүлийн үед сонгууль угтсан сонингууд борооны дараах мөөг шиг олширч байна. Өдөр тутмын сонинуудын холбооны тэргүүний хувьд улс төр дагасан энэ явдлыг та ямраар харж байна?

-Бид олон сонгууль үзлээ. Монголд сонгууль нэг л дүр зургаар болдог. Сонгуулийн өмнө улстөрчдийн маргаан дээд цэгтээ хүрдэг. Бие биенээ муулах, сайн, муугаа уудлах нь хэрээс хэтэрдэг. Дээрээс нь нам байгуулдаг. Тэр хэмжээгээр хэвлэл

мэдээллийн байгууллага олширдог. Эхэндээ түр зуурын сонин гардаг байснаа дараа нь сонингууд гардаг болсон. Одоо телевизүүдтэй боллоо. Бүгд сонгуультай холбоотой. Өөрөөр хэлбэл, монголчууд сонгуулиас сонгуулийн хооронд амьдардаг ард түмэн болсон. Сонгууль дууслаа, маргааш нь улстөрчид амалж байсан бүх юмаа умартдаг. Энэ бүхэн хэвшил болсон зүйлүүд. Тиймээс хачирхаад байх юм алга. Болдог юм болдгоороо л болж байна. Дахиад л

76 мангуу ч гэдэг юм уу, 76 луйварчин ч юм уу, нэг 76 хүн сонгогдоод мөн л идэж уугаад, улс төрийн эрээнтэй бараантай амьдрал үргэлжилдгээрээ үргэлжилнэ. Энд гагцхүү хүмүүс өөрөө өөрсдөө сайхан амьдрах ёстой. Өөр өөрийн хүсэл мөрөөдөлтэй, өөрийн зорилготой, амьдралаа аваад явчих юм бол энэ улстөрчдийн хийж байгаа юм бидэнд ямар падлий байна.

-Саяхан Ерөнхий сайдын хэвлэлийн албаны дарга асан Н.Дэмбэрэлийг хорьчихлоо. Улстөрчид хэвлэл рүү дохиж, зангах нь хэвээр л байна.

-Энд би хоёр зүйлийг онцолмоор байна. Нэгдүгээрт, Монголын сэтгүүл зүй өнөөдөр улс төрөөс маш их хамааралтай байна. Энэ хамаарлыг багасгамаар байна. Үүний тулд сэтгүүлчдэд өөрсдөд нь хийх зүйл их байна. Тэр нь юу вэ гэвэл энэ Их хурлын 76 гишүүнийг, Засгийн газрын гишүүдийг, иргэдийн хөдөлгөөн, цаана нь том нууц зорилготой удирдагчдыг хэтэрхий дөвийлгөж, дандаа эднийг магтан дуулж, тэглээ ингэлээ гэж хэвлэл мэдээллийн мэдээний баатар болгохоо болимоор байгаа юм. Цаана нь маш баян амьдрал байна. Бидэнд мэдээлэх, хэлэх юм өчнөөн байна. Энэ улсуудыг анхаарлын төвөөс гаргаж хаях хэрэгтэй. Сэтгүүлчдээр дамжиж баатар болдог, улмаар Их хурлын гишүүн болж улс төрд ордог, дараа нь тэр хэрээр буцаад сэтгүүл зүйд нөлөөлдөг ийм хөгийн юм маш их байна. Хоёрдугаарт, Монголд сэтгүүлчдийн эрх ашгийг, мэдээлэл олж авах бүрэн эрхийг баталгаажуулах хууль зүйн үндэс муу байна. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний хууль байдаг ч ерөнхий хууль. Цаашид үүнийг улам боловсронгуй болгох шаардлагатай. Үүн дээр үүнийг гадарладаг УИХ-ын эрхэм гишүүд, сэтгүүлчдийн мэргэжлийн холбоод ажиллах хэрэгтэй байна. Тэгэхгүйгээр Дэмбэрэлийг бариад хорьчихлоо энэ тэр гээд дэмий үглэхчээд, мартаад байх юм бол энэ байдал улам л даамжирна.

-Монголын улс төрийн тайзан дээрх эмэгнэлт драм, эрх ашгийн нэгдэл тэмцлийг та сэтгүүлчийн нүдээр хэрхэн харж байна вэ? Монголд ер нь төр, төрийн түшээ

гэдэг ойлголт утгаа алдчих шиг.

-Мэдээж өдөр тутам харж, өдөр тутам бухимдаж, уурлаж сууна. Гэвч өнөөдөр энийг засахад их хэцүү болжээ. Улс төрийн тогтолцоог үндсээр нь өөрчилж, сайжруулахгүй бол засрахгүй. Парламентын хоёр танхимтай болоод, тэр нь бие биенээ хянадаг гэх мэтээр өөрчлөхгүй бол Монголын улс төрд ойрын хэдэн жилд сайн сайхан юм олж харахад хүнд, харанхуй байна. Хонгилын үзүүрт гэрэл харагдахгүй байна.

-Үнэхээр ч Монгол төрөөр энэ хэдэн зайгуул, суугуул нөхөд тоглож идэж уух эрх ашгийн төлөө тэмцэж дууслаа. Эднийг ер нь хазаарлахын тулд таны хэлдгээр бичихээ болих уу? Сэтгүүлчид ер нь ажил хаяж яагаад болохгүй гэж.

-Сэтгүүлчид ажил хаях юм бол улстөрчид их хохирно доо. Улс төрийнхөн "Сэтгүүлчид, бид нарыг магтан дуулж, шүүмжилж, муулж хоолоо олж иддэг" гэж ярьдаг. Үнэндээ эсрэгээрээ. Улстөрчид гэдэг бол хэн ч мэдэхгүй ганзагын наймаачин, нэг жижиг бизнесмен, хэн ч мэдэхгүй нэг хөдөлгөөн байгуулсан нөхөр. Тэд сэтгүүлчдээр дөрөөлж улс төрд орж, улс төрд орсноороо том бизнес эрхэлж, ард түмнийг шулж мөлжиж, авилга, хээл хахууль авч амьдарч байна. Сэтгүүлчид ажил хаяхаа бүр больё, улс төрийн, улстөрчдийн тухай бичихээ больё л доо. Бичихдээ Засгийн газар УИХ ийм ийм шийдвэр гаргалаа гэж бичье. Нэрийг нь дурьдахаа больё. Сэтгүүлчид бүгд нэг бодолтой ингэчих юм бол энэ улс төрчид их зөв амьдарч эхэлнэ. Тиймээс сэтгүүлчиддээ улс төрчдийг сайнаар ч, муугаар ч нэрийг нь битгий дурьд гэж уриалмаар байна. УИХ-ын нэг гишүүн огцорчээ л гэж бичье. Царайг нь хараад танивал тэр л биз. Эд нар чинь бүр үндэсний баатар болчихоод байна шүү дээ.

-Энийг тэгвэл хэрэгжүүлэх гээд үзвэл яасан юм.

-Тэгж болно ш дээ. Ялангуяа сонгуулийн өмнө. Монголын өдөр тутмын сонингуудын холбоонд тийм бодол байгаа. Худал хуурмаг баг зүүсэн улстөрчдийг өөгшүүлэхгүй байх тал дээр л сайн ажилламаар байна. Сонин, телевизийн бүх холбоод ярьж байгаад ийм арга хэмжээ авбал эднийг

хазаарлаж болно шүү. Хазаарлах ч хэрэгтэй байна.

-Ми-8-ын ослоос харахад л одоо бараг хариуцлага хүлээх ч хүнгүй болох шахам. Улс төрд ер нь хүн чанарын хэмжүүр гэдэг магадгүй хамгийн гол шалгуур болох зүйл байдаг биз дээ?

-Манайд бүх юм эсрэгээрээ байгаагийн жишээ энэ. Өөрөөр хэлбэл, хамгийн ичих булчирхайгүй, юу ч хийхээс буцдаггүй, айж ичдэггүй хүн л улс төрд орж болдог гэсэн жишиг өнөөдөр тогтчихлоо. Огцорно гэж өргөдлөө өгчихөөд дараахан нь огцрохоо болилоо гээд өргөдлөө буцааж авч л байдаг. Ийм юм дэлхийн өөр улсад байна уу гэвэл, үгүй. Яг өнөөдөр гэхэд бидний мэддэг хоёр том гүрэнд Засгийн газрын тэргүүнүүд нь огцорчихоод байна. Ялимгүй ялимгүй шалтгаанаар. Үүнийг л манайд нэвтрүүлэхгүй бол Монголын улс төрийн амьдрал явахгүй. Энэ төрийг эмзэглэж, өрөвдөхөөр барахгүй хувь хүний хувьд улс төрд орохгүй юмсан гэсэн бодлыг энэ улсууд бий болгож байна. Жишээлбэл би анхны ардчилсан үндсэн хууль баталж байсан АИХ-ын гишүүн, Байнгын хорооны дарга байлаа. Надад улс төрд орвол орох бодол байна. Улс орноо бодвол. Гэтэл тэнд байж байгаа улсуудыг харахаар тийшээ орж нэр хүндээ бузарлаж болохгүй гэсэн бодол өөрийн эрхгүй төрдөг. Үүнийг нэг хүн эсвэл нэг хэсэг хүн ороод сайжруулна гэж байхгүй. Тогтолцоог нь өөрчлөхөөс наана хэн ч юу ч үүнийг засаж сайжруулж чадахгүй. Би тэр авлигачдын нэг болмооргүй байна ш дээ. Тэр авлигачдыг хараад дур гутаж байна.

-Та өөрийгөө чоно шиг өссөн гэж тодорхойлдог юм билээ. Тэр араншин таны сэтгүүлчийн карьер, бизнесийн амжилтанд нөлөөлсөн нь ойлгомжтой. Одоо харин улс төрд хатуу, чанад араншин тань хэрэгтэй юм биш үү?

-Мэдэхгүй ээ. Улс төрд үгүйлэгдэнэ, хэрэгтэй болно гэж байхгүй байлгүй дээ. Монголын улс төр Ц.Балдоржоор яах юм бэ? Ц.Балдорж Монголын улс төрөөр яах юм. Аль аль нь ангид байж болно.

-Монголын улс төр, бизнест

хүчирхэг гурвал гэж Ерөнхийлөгч асан Н.Багабанди, Ж.Отгонбилэг агсан, та гурвыг нэрлэдэг. Танд ч УИХ-д нэр дэвших санал ирж байгаа биз дээ?

-Надад улс төрд орох бодол одоогоор байхгүй. Хүчирхэг гурвал, бүлэг энэ тэр гэдгийн тухайд би тухайн үед нь ч ярьж байсан. Тийм юм байхгүй. Байгаа ч үгүй. Бид зүгээр найз нөхөд. Түүнээс улс төрийн хүрээнд өөрсдийн нөлөөг бий болгоё, хүчирхэг нөлөөтэй больё гэсэн бодлогоор хийж байсан юм байхгүй. Үүнийг би дахиад хэлж байна. Н.Багабанди Ерөнхийлөгчийн хувьд 50 гарсан эр хүн улс төрийн хүрээнд нөлөөтэй, сонгогчдынхоо дунд нэр хүндтэй байна. Энэ хүн чинь улс төрөөс өөр юу хийх юм бэ? Үүнийгээ орхичихоод тэтгэврийн хүн болж болохгүй биз дээ. Сонгогчид, намынхан нь улс төрд ороосой гэж хүсч, мөрөөдөж байна. Тиймээс улс төрд буцаж орох байлгүй гэж бодож байна. Энэ бол тэр хүний үг биш.

Миний хувийн байр суурь.

-Таны намтраас харж байхад Ц.Балдорж гэдэг хүнийг бурхан ивээгээд ч үү, хувьсгалын тохироо нь бүрдээд бизнест хүч сориод, амжилт олоод яваад байсан дүр зураг харагддаг. Та цаашид өөр бизнест хүч үзэх үү?

-Би эдийн засгийн мэргэжилтэй биш. Сэтгүүлч, түүхийн ухааны доктор хүн. Бизнест аз гэж байна л даа. Тэр аз намайг ивээж байсан. Гэхдээ өөрийн хүч чармайлт хэрэгтэй байлгүй яахав. Цаашдаа өөрийн эрхэлж байгаа салбаруудаа бэхжүүлэе гэсэн бодолтой байгаа.

-Та Монголд ямар юмных нь хэвлэлийн магнат байхав гэж ярих дуртай. Тэгвэл Монголд олигархиуд байгаа юу?

-Олигархи гэдгийг бид хоёр талтай авч үзэх ёстой. Эдийн засгийн, бизнесийн олигархи байх ёстой. Гэхдээ Монголд тэр олигархи нь байгаа ч юм уу, үгүй ч юм уу. Дор хаяж манай

нэг том бизнесийн групп Монголоос гадна Хятад, Оросын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж байгаа юм уу гээд аваад үзвэл олигархи байна гэхэд хэцүү. Хэвлэл мэдээллээр улс төр, бизнесийн олигархи гэж сүүлийн үед их бичиж байгаа. Манай "Өнөөдөр" сонин, 25-р суваг телевиз ч энэ тухай их ярьж, бичдэг. Үүнийг бид шүүмжилсэн утгаар хэлж байгаа юм. Өөрөөр хэлбэл, улс төр бизнесээс тусдаа, бизнес улс төрөөс тусдаа байх ёстой. Гэтэл улс төрийнхөө нөлөөгөөр бизнес эрхэлдэг эсвэл улс төрийн нөлөөнд орж бизнесээ хөгжүүлдэг гаж тогтолцоо Монголд бий болчихоод Монголд бизнес улс төрийн олигархийг бий болгоод байна. Энэ аюултай гэж сэрэмжлүүлэх үүднээс ингэж бичиж байгаа. Энэ бол маш аюултай үзэгдэл. Тэрнээс олигархи гэж жинхэнэ утгаараа байхгүй.

"Монголын нэг өдөр" сонин 2007 он ■

ЗАСАГЛАЛ

Холын зорилго үгүй бол ойрын зовлон оршино



П.Цагаан
/Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга/

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга П.Цагааны "Холын зорилго үгүй бол ойрын зовлон оршино" нийтлэлийг хүргэж байна. Бичсэн хугацаа нь нэлээд хэдэн сарын өмнө боловч төр самуурч, эзэнгүй улс шиг байгаа одоо цаг дор энэхүү нийтлэлийн үнэ цэнэ их ажгуу. Ялангуяа төрийн жолоо атгалцаж байгаа хүмүүсийн бодлогын алдаа, басхүү тэдэнд сургамж болох, санаа авах олон зүйлийг оюун санаагаа чилээн байж бичжээ.

Худлааг мэдэх тэнхэлгүй, үнэнийг сонсох итгэлгүй энэ үед уг нийтлэлийг унших орон зай олдох нь дамжиггүй.

Манай улсын эдийн засаг агшиж, валютын нөөц шавхагдаж, төгрөгийн ханш сульдаж, төсвийн орлого хумигдаж, хөрөнгө оруулагчид дайжиж байгаа нь монголчууд бидний өмнө тулгарч байгаа хүндхэн сорилт. Энэ бол нууц биш. Товчхондоо, том зорилтууд алсарч, ойрын зовлонд сөгдөх нь байна.

Өнөөдөр Монголд илтэд дайсагнасан улс орон нэгээхэн ч алга. Манай улсын эсрэг эдийн засгийн болон улс төрийн хориг арга хэмжээ авсан зүйл алга. Харин ч Монгол Улсын гадаад харилцаа сүүлийн жилүүдэд нэн таатай байгаа. Тийм болохоор өнөөгийн эдийн засаг, төсөв, санхүү, хөрөнгө оруулалтын хүндрэл, бэрхшээл, нүүрлэж болзошгүй хямралын аюулын учир шалтгааныг гаднаас биш, дотоодоосоо, өөрсдөөсөө хайх нь зүйд нийцнэ.

Миний бодлоор, өнөөгийн хүндрэл

бэрхшээлийн шалтгааныг манай экспортын бүтээгдэхүүний үнийн уналт, өмнөх засгийн бодлогын алдаа оноотой холбон тайлбарлаж, амиа аргацааж болох ч, ужгирсан гурван гол шалтгаан байна. Эхнийх нь Үндсэн хуульд оруулсан дордуулсан өөрчлөлтүүдээс улбаатай болон улбаагүйгээр төрийн босго намсч, боловсон хүчний бодлого алдагдсан. Удаах нь төр засгийн хэврэг бүтэц. Гурав дахь нь хууль, эрх зүйн төгөлдөршөөгүй, тогтворгүй орчин.

ТӨР БАРИХ УХААН

Дэлхий дахинд төрт ёсыг түгээн төвхнүүлж явсан бидний өвөг дээдэс төр барихуйн арвин их түүх, туршлага, соёлтой байсан. Хаад, ноёд төрийн түшээ болох хүмүүсийг яг л аргамаг хүлгээ шинжих мэт үйл хөдлөл, ухаан бодол, зан төлөв, хүний мөс, ноён нуруу, авьяас чадварыг нь шинжин тодруулж, хэр чинээнд нь таарч тохирох ажил даалгадаг байжээ. Учир нь тэдний ажил, үйлсээс төрийн үйл хэргийн хувь заяа, сүр сүлд цогцолдог байсанд оршино.

Орчин цагт ч ялгаагүй, улс орнууд авьяас чадварт суурилсан мерит тогтолцоо руу шилжиж, өөр хоорондоо өрсөлдөж байна. Манай улс 1990 оноос өмнө де-юре тусгаар тогтносон улс байсан. Гэвч түүний удирдагчид, боловсон хүчний бодлогыг олон жилийн туршид харийн орон тодорхойлж, оролцдог байсан нь гашуун үнэн. Тиймээс бие даасан улс төрийн бодлого, боловсон хүчний бодлого явуулах түүхэн боломж олгосон Ардчилсан хувьсгалын дараа 1992 оны Үндсэн хуулийн төслийг боловсруулж батлахдаа нийт ард түмнээрээ шүүн хэлэлцүүлж, ардчилсан төрийн тогтолцоо, боловсон хүчний бодлого, тэдгээрийн уялдаа холбоонд онцгой анхаарч олон чухал заалт оруулсан.

Ингэхдээ Монголын түүх шаштир, сургамж, бас гадаадын ардчилсан улс орнуудын хууль, практик, Үндсэн хуулийн эрх зүйн онол, сургааль зэргийг судалж, харгалзсан. Зарим тодорхой санааг ч авсан. Тухайлбал, төрийн албан тушаалтныг зөвшилцөж томилох зарчим. Гол санаа нь төрийн нэрийн өмнөөс, төрийн чухал



үйл хэргийг гүйцэлдүүлэх өндөр хариуцлагатай албан тушаалтан томилогдохдоо гүйцэтгэх болон хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлж буй сүбъектүүдийн дэмжлэгийг авсан байх болзол. Аль алиных нь дэмжлэгийг авна гэдэг бол төрийн албаны өндөр шаардлага, босгыг давж байна гэсэн үг. Гэтэл өнөөдөр “зөвшилцөнө” гэдэг нэг нэр томъёог язгуур утга санааг нь гуйвуулж, “дэмжсэн бол томилно”, “дэмжээгүй бол өөр нэр дэвшигч оруулж ирнэ”, “дэмжихгүй байсан ч томилно” гэсэн гурван өөр утга санаа бүхий хувилбараар хэрэглэж байна.

Хэдэн жилийн өмнө АНУ-д төрд чухал алба хаших хүмүүсийг яаж зөвшилцөж томилдогийг ажигласан юм. АНУ-ын Ерөнхийлөгчийн шалгуурыг даваад ирсэн Дээд шүүхийн гишүүнд нэр дэвшигчийг дэмжих эсэхээ шийдэхийн тулд Сенат тухайн нэр дэвшигчийн өмнө гаргасан шүүхийн тогтоол шийдвэр, бичсэн бүтээл, хэлсэн үг зэрэг бүх л мэдээллийг судалж, дүгнэлт хийлгэж байж билээ. Ингэж л итгэл даах хүнд төрийн жолоо, цулбуурыг атгуулдаг ажээ. Тийнхүү зөвшилцлөөр томилогдож байгаа хүн нь ч, үйл явц нь ч бүхэл бүтэн үйл явдал, хэвлэл мэдээллийн хэлэлцүүлэг болон өрнөж, олон түмний итгэл, дэмжлэг, хариуцлага болж хувирдаг.

Боловсон хүчний хязгаарлагдмал нөөцтэй манай орны хувьд нам, нам бус, нутаг нуга, фракцаар хувааж байгаа нь Монголын ард түмний язгуур

эрх ашигт нийцэхгүй. Ардчилсан нийгэм, зах зээлийн эдийн засгийг тууштай дэмждэг, мэргэжилдээ сайн эрдэм номтой залуусыг төрийн албанд оруулж, сургаж, дэмжих цаг ч болж. Тэдний тархийг улс төржүүлж, нийгмийн хуваагдлыг гүнзгийрүүлэх ёсгүй. Үүний тулд намын хатуу гишүүнчлэлийг цуцлах хэрэгтэй. Намууд ч фракцаасаа татгалзах учиртай.

ХЭВРЭГ, ОЙ САНАМЖҮЙ БҮТЭЦ

Саяхан нэг томоохон хөрөнгө оруулагчтай уулзтал, “танай улсад хөрөнгө оруулах төслийнхөө талаар нэг жил хэртэй хугацаанд судалгаа хийгээд, шийдвэрээ гаргачихаад ирсэн чинь танай Засгийн газар, Ерөнхий сайд солигдчихож. За яахав, байж болох л юм. Хамгийн гайхширалтай нь бидэнтэй харьцаж байсан яам бүрмөсөн алга болчихож. Яамдыг хуулиар байгуулдаггүй юм уу? Цаашид бид татварын орчин тогтвортой байх эсэхийг судлахаас гадна харьцаж байгаа яам, агентлаг маань тогтвортой байх эсэхийг нь тандаж мэдэх нэмэлт ажил гарч байна” гэв. Хариулт олдсонгүй.

Манай өвөг дээдэс, ахмад үеийнхэн маань төр, засгийн бүтэц зохион байгуулалт, нэрийг тогтвортой байлгахыг эрхэмлэдэг байв. Богд хаант Монгол Улсын үед ч, Ардын засаг байгуулагдахад ч таван яамтай л байлаа. Гэтэл одоо, Ерөнхий сайд болгон УИХ-аас томилогдоод

ажлынхаа өрөөтэйгээ танилцахаас өмнө төрийн яамд, агентлагуудыг салгаж, нийлүүлж, татан буулгаж, нэр, хаягийг нь сольж бужигнуулна. Тэр ч бүү хэл яам, агентлагийг тухайн нэг намын мэдэлд өгөх, бүр сүүлдээ фракцад “өмчлүүлдэг” болсон нь гунигт үнэн.

Ерөнхий сайдыг залгаад шинээр томилогдсон сайд, дарга нар болгон очсон яам, агентлагийнхаа бүтэц зохион байгуулалт, боловсон хүчнийг бужигнуулж, төрийн жинхэнэ албан хаагчдыг үүрээ эвдүүлсэн шоргоолж шиг болгоно. Төрийн ажил зогсч, ой санамж саажиж эхэлнэ. Энэ дайрлагын сүүдэр, эцэс төгсгөлгүй маргаан дараагийн сонгуультай залгана. Сонгуулийн дараа энэ чөтгөрийн тойрог дахин давтагдана.

Энэ бүгд бол Монголын ардчилсан төр засгийн бүтэц, зохион байгуулалтыг хэврэг дархлаагүй, ой санамжгүй болгож, бяд муутай, мөлхөө байлгах хорлонтой, харалган, халагламаар үйлдэл. Үүнийг таслан зогсоох, хуулиар хориглох цаг болсон. Төр улс гэдэг бол нэг том айл гэр. Тэр айлын аав, ээж хүүхдүүдээ “муу сурлаа”, “амлалтаа биелүүлсэнгүй” гээд жил болгон нэрийг нь солиод байдаггүй биз дээ. Яамд, байгууллагынхаа дотоод зохион байгуулалт, ажил, үүргийг нь л зөв оновчтой болгоно биз.

АНУ зуун жил есөн яамтай байж байгаад өнгөрсөн зуунд Хөдөлмөрийн яам нэмж байгуулсан. Түүний нэг үүрэг нь Үндэсний статистик. Энэ зуунд нэг яам шинээр байгуулсан. Тэр нь 9 сарын 11-ний террорист халдлагын дараа байгуулагдсан Аюулгүй байдлын яам. Нэг яамны дундаж нас нь 170 жил. Тэгвэл манай улс сүүлийн 25 жилийн дотор яамдын тоо, нэр, хаягийг хэдэн удаа юу гэж өөрчлөснийг бүрэн санах хүн олдохоо больсон.

ХОРЖООНТОЙ ХУУЛИУД

Нэгэнт бид эрх зүйт төрийг сонгосон болохоор нийгмийн харилцааг хуулиар удирдаж, захирна гэсэн үг. Хууль боловсруулах, батлах гэдэг мэргэжил шаардсан, судалгаа шаардсан, холын үр дагавар дагуулах нэн хариуцлагатай ажил.

Гэтэл тооцоо судалгаа, ул суурьтай бодлогогүй, сэтгэлийн хөөрлөөр

баталсан хуулиудын нийгэмд үзүүлж байгаа сөрөг үр дагавар нь хөрөнгө оруулалт, баялаг бүтээгчийг дайжуулж, олон хүний амьдралыг туйлдуулж байна. Жишээ 1: Улсаа баяжуулах сэдэлтэй 68 хувийн татварын хууль улсаа ядуурал руу түлхснийг хүн бүр мэднэ. Жишээ 2: УИХ-д дахин сонгогдох гэсэн хувийн сэдэлдээ хөтлөгдсөн гишүүд 2012 оны сонгуулийн өмнө Стратегийн хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай шинэ хууль баталснаар манай улсад орж ирэх их хөрөнгө оруулалтыг шууд утгаараа бүрэн зогсоосон. Жишээ 3: Манай улсын төр, засгийн тэргүүн нар гадаадад очоод хөрөнгө оруулагчдыг уриад дуудаад, даллаад л байдаг. Гэтэл гадаадаас орж ирсэн 20 мянган ам.доллараас дээшхи мөнгөн гүйлгээ болгоныг нэрийг нь чанга хэлэхээс ч хүмүүс айдаг болсон гурван үсэгтэй газар хянаж байхад наашаа зүрхлэх хөрөнгө оруулагчид хэр олон байх бол?

Нэмээд хэлчихэд, дугаар ерөнхийлөгчийн Үндсэн хуулийн суурь зарчмыг зөрчин байж өөртөө зориулж бүтээсэн чөтгөрийн цалмыг эртхэн эвхэж, хураахгүй бол улс үндэстнээрээ их үнэ төлөх нь.

ӨРӨМ АМАЛСАН ТОГТВОРГҮЙ ХУУЛИАС ХУСАМ АМСУУЛСАН ТОГТВОРТОЙ ХУУЛЬ ИЛҮҮ

Шинэ Засгийн газар, шинэ Ерөнхий сайд болгон, тэр бүү хэл УИХ-ын гишүүд хүртэл татварын хуулийн өөрчлөлт хийхээр амладаг, бас амлалтаа ч биелүүлдэг. Ардчилсан улсад татвар санаачлах эрх зөвхөн Гүйцэтгэх эрх мэдэл буюу засгийн газарт, бүр нарийн яривал Сангийн сайдад хадгалагддаг бөгөөд харин түүнийг батлах эсэх нь татвар төлөгчдийг төлөөлж сонгогдсон хууль тогтоочдын эрх мэдлийн асуудал байдаг. Татварын хууль санаачилахдаа татварын бааз суурийг өргөтгөнө, төсвийн орлогыг нэмэгдүүлнэ, хөрөнгө оруулалтыг татна гэх мэт эгшиглэнтэй тайлбарладаг боловч үнэн хэрэгтээ үр дүн нь эсрэгээр гардаг. Бизнес эрхлэгчид, хөрөнгө оруулагчид тухайн орны хуулийг сайн, саар хууль гэхээсээ илүү тогтвортой, тууштай, алагчлалгүй мөрдөгддөг байхыг хүсдэг. Аз жаргалын эрэлчнээс бусад

хариуцлагатай хөрөнгө оруулагчид ажил, бизнесээ олон жилээр төлөвлөдөг. Тийм болохоор тэдэнд өрөм амалсан тогтворгүй хуулиас илүү хусам амлуулсан тогтвортой хууль илүү чухал. Энэ бол маргашгүй үнэн. Ийм учраас татварын суурь хуулиараа ойр ойрхон бүү оролд. Сонирхуулахад, Норвеги улс эрдэс баялгийн салбараа зөв ашиглаж, дэлхийн хамгийн баян Сантай болсны нууц нь сайтар бодож баталсан хуулиа 50-60 жил тууштай мөрдөж чадсанд оршино. Өрөслдөх чадварын 10 алтан дүрмийн нэг дэх нь Хуул, эрх зүй, захиргааны тогтвортой орчин.

Өөр нэг хүлээн зөвшөөрөх асуудал бол даяаршиж байгаа өнөө үед Монголын хууль, хуулийн байгууллагын үйл ажиллагааны стандартыг олон улсын нийтлэг хууль, үйл ажиллагааны стандартанд нийцүүлэх бодлого явуулах цаг болсон. Дэлхий Монголтой нийцнэ гэвэл эндүүрэл.

Ардчиллын амин сүнс бол хүний эрх, эрх чөлөө, халдашгүй байдал. Зах зээлийн эдийн засгийн амин сүнс нь хувийн өмч, түүний батлагаа. Хэрэв Монгол улс сүүлийн жилүүдэд “Human rights and freedom, Habeas corpus, Due process, Property rights, Laissez faire, Business privacy, Pacta sunt servanda, Supremacy of international treaty, jus cogens, Non-retroactivity, Stability and continuity, Grandfather clause” гэх зэрэг соёлт хүн төрөлхтөний бүтээсэн хүний эрхийн болон бизнесийн эрх зүйн суурь зарчмыг тууштай баримталсан хууль баталж, чанд мөрдүүлж чадсан сан бол одоогийн олон бэрхшээл, гарз хохирол бидэнд учрахгүй байх байсан болов уу.

“Төр барих, төлөг хариулах хоёр ялгаатай”, “Төрийн ачааг түшмэдүүд, Түмний ачааг тэмээ үүрдэг”, “Зусар, хов хоёр ихэрлэхэд, Засагт цас зуд нүүрлэдэг”, “Ухаант хүн ч будилна, Уургын морь ч хадуурна”, “Улс төрийн өвөр түрий, Улс орны гамшиг”, “Хувьсгалыг бадраахад зориг, Хуулийг сахихад тэвчээр” гэсэн ахмадын сургаалийг санахад илүүдэхгүй болов уу?

2015.04.04

\Үргэлжлэл бий\ ■

Хөгжлийн гүнээс



Оюутолгойн хөрс хуурай, чийг багатай. Гэвч, баригдсан хонгилын энд тэнд ус шүүрсэн байхтай таарна

Ц.Элбэгсайхан

Дуулга дээрх гэрлийнхээ тусламжтай л ямар зүйлд суун газрын гүн рүү “унаж” яваагаа харж байлаа. Оюутолгойн гүний уурхайн төслийн удирдагч Эндрью Хүүппел бидний хэдэн сэтгүүлчийг энэ харанхуй цахилгаан шат шиг зүйлд дагуулан суусан юм. 1300 метрийн гүн рүү секунд тутамд зургаан метрийн хурдтай доошилсоор дөрөвхөн минутын дараа зорьсон гүндээ хүрлээ. Далайн түвшнээс доош 135 метрт иржээ. Биднийг гүний уурхайд нэвтрэхээс өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч, осол аваар болох, агааргүйдэхэд хэрэглэх хүчилтөрөгчийн сав зүүж өгч, онцгой

тохиолдолд хорогдох байранд хүргэж өгөх хэдэн хөтөч дагалдан яваа юм.

Гадаа өдөртөө -26 хэм хүртэл хүйтэрч байхад газар доор биднийг +25 хэмийн дулаан орчин угтав. Зааварчилгааны дагуу бидэнд зочны нэвтрэх үнэмлэхээ цахилгаан шатнаас буусан даруйдаа самбарт өлгөөд “аялалдаа” гарлаа. Үүний адил бас нэгэн үнэмлэхийг цахилгаан шатанд суухаас өмнө дээр үлдээсэн юм. Гүний уурхай руу буусан ажилтан бүр өөрийн мэдээлэл бүхий хоёр үнэмлэхтэй байж нэгийг нь буухын өмнө, нөгөөг нь уурхайн гүнд буусан түвшинд өлгөнө. Харин гарахдаа буцаан авахаа мартаж болохгүй. Учир нь гүний уурхайд нэг

дор 146 хүн л ажиллана. Нэг хүн орохын тулд өөр нэг нь гарах ёстой болдог байна.

Далд уурхайн бүтээн байгуулалттай бидний танилцуулж буй гол хүн Эндрью Хүүппел бид гүний уурхайн гүн рүү дагуулан орлоо. Уурхайн хонгилоор том машин техникүүд явдаг тул уужим саруул. Ойролцоогоор өргөн нь 10 метр, өндөр нь 12 метр. Уурхайн ханыг өндөр хатуулаг бүхий бетон зуурмагаар хүчитгэсэн, зам нь ч даац өндөртэй, олон үе давхарга бүхий бетон байх ёстой. Гүний уурхайд 200 орчим км хонгил барихаас 16 километрийг нь бариад байгаа. Энэ хэсэгт ажилчдын оффис, хоолны

газраас эхлээд машин техникийн засвар үйлчилгээний цех, тоног төхөөрөмжийн агуулах, шатахуун түгээх станц, олборлосон хүдрээ хадгалах агуулах барьж байгаа юм. Энэ бүхнийг ноён Эндрью Хүүпелийн удирдлага дор монгол залуус маань барьж бүтээж буй. Ханын хүчитгэл хийгдэж дууссан, зам барих ажил эхлээд явж байгаа бол агуулах бараг дуусчээ. Ханын хүчитгэлийг давхар төмөр торон бэхэлгээтэй хийжээ. Гүний уурхайн бүтээн байгуулалттай танилцсан “Рио Тинто”-гийн Санхүү эрхэлсэн гүйцэтгэх захирал Крис Линч бүтээн байгуулалтын ажлыг “олон улсад туршлага болохоор мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэжээ” хэмээн сайшаасан байна.

Бидний танилцсан эхний зүйл нь хоргодох байр. Нэг хоргодох байранд 20 хүн багтах бөгөөд дөрөв хоногийн турш хүрэлцэх цэвэр агаар, цэвэр усаар хангагдана. Хүн бүр хэвтээд байх боломжгүй ч чөлөөтэй хөдөлж болохоор юм. Дотроо хүчилтөрөгчийн бортого, холбооны төхөөрөмж, цахилгааны эх үүсвэр, анхны тусламжийн хэрэгсэл бас бус чухал хэрэгцээтэй зүйлүүд бий. Хоргодох байрны тоо ажилчдад хангалттай хүрэлцэхүйцээр буюу нийт ажилчдын 20 хувьд хүрэлцэхүйц байхаар илүүг төлөвлөсөн аж.

Оюутолгойн хөрс хуурай, чийг багатай. Гэвч, баригдсан хонгилын нэгээхэн хэсэг газар ус шүүрсэн байхтай таарсан нь төсөөлж байгаагүй зүйл байв. Говь нутгийн хөрсөнд, тэр тусмаа 1300 метрийн гүн дэх энэ чандмань нэлээд давсархаг юм. Ус хонгилын таазнаас бага багаар шүүрч, дусалдаг бололтой. Орой дээрээс унжсан давсны тогтоц бий болгожээ. Давс нь харин бидний өдөр тутам хэрэглэдгээс ч гашуун амтагдаж байлаа.

Дашрамд дурдахад говьд илэрсэн усны нөөц бүс нутгийн хэрэгцээг багадаа 20 жил хангаж хүрэлцэнэ гэдгийг доктор З.Цэрэндорж нар судалж тогтоосон байдаг.

Ерөнхийдөө гүний аяллын бүх зүйл сонирхолтой байлаа. Товчхондоо, газрын дээр ч үзэж байгаагүй том бүтээн байгуулалтыг энд байгуулчихаж. Энэ доор ажиллахад тэр дээр ажиллахаас

орчин нөхцөл илүү юу гэхээс дутуугүй. Наад зах нь агаарын температур нь тогтмол. Гэтэл хөрсөн дээр улирлаас хамаараад агаарын температур 50-60 хэм хэлбэлзэнэ.

Одоохондоо, гүний уурхайн бүтээн байгуулалт зогсонги байгаа. Машин техникүүд ажлаа хүлээн чимээгүй. Уурхайн хонгилоор багаж барьсан, ажлаа хийж байна уу гэхээр нэг ч хүн үл зөрнө. Ихэнх хонгил түнэр харанхуй. Энэ эл хуль байдал Оюутолгойн гүнд хоёр жил гаруй ноёлжээ. Зөвхөн 10 орчим ажилтан машин механизмаа зэврэхээс хамгаалж арчилдаг байна. Гэхдээ бүтээн байгуулалтын бэлтгэл ажил үргэлжилж байгаа. “Туркойз хилл

хоёрдугаар босоо амыг ирэх онд ашиглалтад өгөх бөгөөд түүгээр хүнээ аварга том машин техникүүдийнх нь хамт зөөж байх юм.

Газрын дээр ил уурхайн олборлолт хэвийн үргэлжилнэ. Баяжуулах үйлдвэр бүрэн хүчин чадлаараа ажиллаж хоногт 100 мянган тонн хүдэр боловсруулж байна. Оюу толгой нь “Рио Тинто” компанийн хэмжээнд хамгийн бага бэртэл гэмтэл бүртгэгддэг, аюулгүй ажиллагааг сайн хангадаг уурхайн нэг. Энэ оны эхний есөн сарын байдлаар 273 хоногийн 259 хоногт нь гэмтэл, бэртэлгүй ажилласан тухай компанийн тайланд дурджээ. Үүний хэрээр ажил зогсохгүй урагшилж



ресурс” 2016 оны хоёрдугаар улирлын эхээр уурхайн бүтээн байгуулалтыг эхлэх шийдвэр гаргана гэж тооцоолж буй.

Гүний уурхайтай танилцах бидний аялал дуусч гарах цаг боллоо. Самбарт өлгөсөн нэвтрэх үнэмлэхээ авч, өнөөх хурдан тээвэрлэгчдээ суун газрын гадарга руу өгсөж байна. Цахилгаан шатны дээхэнд байх нарийхан зурвас хэсгээр саарал бетон хана жирлэх нь үзэгдэнэ. Бидний зорчиж байгаа энэ шат бол хүн тээвэрлэхэд зориулж барьсан нэгдүгээр босоо амынх. Гүний уурхайг газрын гадаргатай холбосон таван босоо ам баригдана. Одоогоор гурвыг барьж, хоёр нь ашиглалтад ороод байна. Ашиглалтад орсон нөгөө нэг нь агааржуулалтад зориулж барьсан тавдугаар босоо ам. Харин

байгаа гэсэн үг. Ер нь Оюутолгойд бүх зүйл ном ёс, дэг журмын дагуу явах ёстой. Машинд суувал хоёр метр ч явсан, хорин километр ч явсан суудлын даруулга зүүж явна, ажлын талбайд заавал хамгаалалтын хувцас, дуулга, цацруулагчтай хантааз өмсөх ёстой. Үүнийгээ бүгд ёсчлон дагана. Газрын дээр олж уншсан “Бүжигчин болох мөрөөдөлтэй охины аав 30 мянган вольттой ажиллаж байна” гэсэн ганц өгүүлбэрээр их олныг өгүүлжээ. Энд хүн бүр аюулгүй ажиллагааны дүрмийг ёсчлон дагадаг нь түүний ач холбогдол, ашиг тусыг бүрэн ухамсарласных. Тэр ч утгаараа эндхийн ажилчид аюулгүй орчин бүрдүүлэхийн төлөө өөрсдөө санаачлага гаргаж, хэрэгжүүлж байна. Тухайлбал, 290 тонны даацтай ачааны машины жолооч нар ээлж

солихдоо гүүр ашиглах болжээ. Гүүр ашигласнаар илүү аюулгүй болсны дээр ээлж солих хугацаа ч богиносчээ. Аюулгүй ажиллагааг зөвхөн мөрдөөд зогсохгүй, аюулгүй ажиллагааг хэвшил болгох хэрэгтэйг тэд ойлгодог. Үүнийг тэд “Эрсдэлийг үзүүлэх төв”-ийн сургалтаас олж авдаг. Уг сургалтын танхим дахь тоног төхөөрөмжүүд өчүүхэн зүйл орхигдуулахад ямар том эрсдэл үүсч болохыг үзүүлэх зорилготой. Түүнийг нэг удаа нүдээр үзэхэд насан туршдаа мартахгүйгээр ой тойнд бичигдэж үлдэнэ. Ерөөс

эрсдэл бидний амьдралд алхам тутам тохиолдож байдаг бөгөөд энд ажиллагсад аюулгүй ажиллагааг өөртөө хэвшил болгосноороо гэр бүлийнхэндээ, үр хүүхэддээ сайнаар нөлөөлж, үлгэр дууриал болдог байна.

Энд тодорхой байгаа нэг зүйл бол тэд хөгжиж байна. Одоогоор уурхайд 4000 орчим хүн ажиллаж байна. Гүний уурхайн бүтээн байгуулалтын ажил дахин эхэлснээр ойролцоогоор 3000 ажлын байр шинээр бий болно. Тэр бүх хүн уурхайд түр байрлаж, гэр ажлын хооронд асар хол орон

зайг туулж, их цаг хугацаа үрж буй. Өдөр бүр “Ханбумбат” нисэх онгоцны буудалд 100 хүн ирж, буцаж байна. Хэрэв ажилчдын гэр сууцнууд олон давхар орон сууцаар солигдвол магад энд 5000 мянган гэр бүл ажиллаж амьдарч, түүнийгээ даган үйлчилгээ нь хөгжиж төд удалгүй томоохон хот, хөгжлийн тулгуур бүс болно доо гэсэн бодол Оюутолгойг орхих зуурт төрж байлаа. Суурь дэд бүтэц ч бий болжээ. Үнэхээр ч зорилгоо харж, дэг журмыг сахидаг газарт тэр цаг нэг их холгүй биз ээ. ■

ОЮУТОЛГОЙ

Ц.Буян

Одоо бизнес эрхлэгчдэд ил, далд нэг асуулт бий. Эдийн засаг эргээд 17 хувь хүрч өсөх болов уу?

Ерөнхий сайдын “Оюутолгойн гүний уурхайн бүтээн байгуулалт гацаанаас гарч, бодит ажил хэрэг боллоо. Та бүхэнд шинэ сэргэг, эерэг сайн мэдээ дуулгая. Олон улсын банкууд 4,2 тэрбум ам.долларын төслийн санхүүжилт олгохоор энэ долоо хоногт эцэслэн шийдвэрлэсэн байна. Арванхоёрдугаар сарын 16-нд Улаанбаатар хотод албан ёсоор баталгаажуулж, олон улсад зарлахаар товллоо” гэж хэлэхийг сонсоод баярласан хүн олон биз ээ. Үгүй дээ гэхэд уурхайгаас цомхтголд орж ажилгүйчдийн эгнээнд шилжсэн зуу зуун хүн, тэдний гэр бүлд сайхан мэдээ. Мөн Оюу Толгойн гадаад, дотоодын ханган нийлүүлэгчдийн хүлээж байсан мэдээ.

2011 оны “супер” өсөлтөд Оюу толгойн нөлөө их бий. Мэдээж хэрэг супер циклийн оргил үе тохиосон нь давхар нөлөө болсон. Хямрал үүссэн шалтгаан нь төлбөрийн тэнцлийн алдагдал буюу олсон бүхнээ импортын бараанд урсгаад алдчихсан хэрэглэгч орны “зовлон” гэдэг дээр ихэнх эдийн засагчид санал нэгдэж байна. Оюу толгойн бүтээн байгуулалтын ажлыг түр зогсоосноос төслийг даган орж ирсэн гадаадын хөрөнгө оруулалт эргэн гарч одсон гэж тайлбарлаж ч болно. Зарим тоог сөхвөл Оюу толгойн



Гүний уурхайн олборлолт эхэлснээр жил бүр 1.8 сая тонн баяжмал үйлдвэрлэнэ.

Макро хөшүүрэг

бүтээн байгуулалт үргэлжилсэн 2009-2012 онд манай улсын гадаадын хөрөнгө оруулалт 1.3 их наяд төгрөгөөс 6.4 их наяд хүрч өссөн. Харин бүтээн байгуулалтыг гацаасан жилүүдэд гаднын хөрөнгө оруулалтын дүнг илтгэх тооны араас хоёр “тэг” хасагдаж өнөөдөр 70 сая ам.доллар болж шалдаа унасан. Энэ нь том төсөл, хөрөнгө оруулалтын өсөлт шууд уялдаатай гэж тайлбарлах үндэс болж байгаа юм.

Долларын ханш дээшилж иргэдийн худалдан авах чадвар муудсаар буй эдийн засагт Оюу толгойн зургаан тэрбумын хөрөнгө оруулалт хэрхэн нөлөөлөх вэ. Хэвтрийн эдийн засгт

хүч тамир өгч чадах уу гэдэг асуулт нийгэмд бий. Манай сэтгүүл үүнд хариулт олохыг оролдлоо.

“Оюу Толгой” ХХК-ийн Монголын талын хувийг эзэмшигч “Эрдэнэс Оюу Толгой” ТӨК-ийн танилцуулгад дурдснаар Оюу толгой төслийн Монгол Улсын хүртэх үр өгөөжийн нэгд “2019 онд Монгол Улсын ДНБ 35 хувиар өснө” гэжээ. Энэ нь гүний уурхайн бүтээн байгуулалт зогсож, зэсийн үнэ унана гэж тооцоолоогүй үеийн төсөөлөл байх. Монголын эдийн засгийн өсөлт оны эцэст 2.3 хувьтай байх таамгийг Дэлхийн банк гаргасан. Ирэх онуудад эдийн засаг долоон хувь давсан өсөлт үзүүлэхгүй гэж

олон улсын санхүүгийн байгууллагууд тооцоолж байгаа.

Гэхдээ тэдний тооцоолол нөхцөл байдал, үйл явдлын өрнөл, бусад хүчин зүйлээс хамаарч байнга өөрчлөгдөж байдаг. Нийт баялгийн 80 хувьд хүрч олборлох гүний уурхай урагшилснаар эдийн засагт эерэг нөлөө үзүүлэх нь дамжиггүй. 2009 онд хөрөнгө оруулалтын гэрээ байгуулж дөрвөн тэрбум ам.долларын хөрөнгө орж ирэхэд эдийн засаг хоёр дахин тэлсэн. Тэгвэл энэ удаад зургаан тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийж бүтээн байгуулалтын ажил зургаа орчим жил үргэлжилнэ. Шинээр 3000 орчим ажлын байр бий болно. Оюу Толгой ХХК өнөөдрийг хүртэл бараг нэг тэрбум ам.долларын татварыг улсын төсөвт төвлөрүүлжээ. 2019 онд биш юм аа гэхэд 2021 онд эдийн засгийн өсөлтийг 35 хувь хүргэх зорилтыг одоо тавьж болох юм. Үндсэндээ гүний уурхайн хөрөнгө оруулалт хийгдсэнээр Монгол Улсын эдийн засаг жил бүр ойролцоогоор 10 орчим хувийн өсөлтийг автоматаар бий болгоно. Гэхдээ энэ их хэмжээний мөнгө эдийн засагт шингэж, бодит үр ашгаа өгөх хүртэл 2-3 жил шаардлагатай гэдгийг эдийн засагчид хэлж байгаа юм. Нэг

үгээр хэлбэл яг маргааш бүх зүйл сайн сайхан болчихгүй нь. Түүнчлэн ирэх жилүүдэд бондын эргэн төлөлтөд Засгийн газар нэлээд том зарлага гаргана.

Хоёрдугаарт, зах зээл дээрх таваарын ханш шийдвэрлэх нөлөөтэй. “Рио Тинто” группийн Монголыг хариуцсан захирал С.Мөнхсүх ирэх жилүүдэд зэсийн үнэ ихээхэн хэлбэлзэлтэй байж, 2019-2021 онд эргэн өснө гэсэн хүлээлттэй байгаа талаар Хонгкогт болсон “Монголд хөрөнгө оруулагчдын чуулга” уулзалтын үеэр ярьжээ. Энэ хугацаанд дэлхийн зах зээл дээр шинэ уурхай ашиглалтад орохгүйн дээр одоо ажиллаж байгаа уурхайнуудын хүдрийн баяжмалын агуулга багасч байгаа. Мөн шинээр бий болж буй технологиудад зэсийн хэрэгцээ их байгаа учир эрэлт ихэсч, нийлүүлэлт багассан цаг үед гүний уурхай ашиглалтад орох төлөвтэй байгааг тэрээр хэлжээ. Гүний уурхайн олборлолт эхэлснээр жил бүр 1.8 сая тонн баяжмал үйлдвэрлэнэ. Энэ нь ойролцоогоор 600 орчим тонн цэвэр зэс болно.

Ерөөсгадаадын хөрөнгө оруулагчид Оюу толгой төсөл хэрхэхээс хамаарч

хөрөнгө оруулах эсэхээ шийднэ гэдгээ өнгөрсөн хугацаанд илэрхийлж ирсэн. Өнгөрсөн сард болсон “Оюу толгойн хөрөнгө оруулагчдын чуулган”-д төсөлд ханган нийлүүлэгч болох сонирхолтой 600 орчим аж ахуйн нэгж, компани оролцсон. Тэдний 400 нь монгол компани байсан юм. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Бямбасайхан хэлэхдээ “Энэ хөрөнгө оруулалтыг дагаад ирэх зургаан жилийн хугацаанд маш олон бизнесийн боломж бий болно” хэмээсэн. Ялангуяа барилга угсралт, өрөмдлөг, түлш, тоног төхөөрөмж нийлүүлэгчдэд том боломж нээгдэж буйг “Оюу Толгой” ХХК-ийн Ерөнхийлөгч бөгөөд Гүйцэтгэх ерөнхий захирал Эндрью Вүүдлэй хэлж байсан. Одоогоор Оюу толгой төсөл өдөр бүр 10,4 тэрбум төгрөгийн бараа үйлчилгээг худалдан авдаг гэсэн тоо бий. Түүнчлэн гүний уурхайг ашигласнаар монголчууд дэлхийд ховор ашигладаг, дэвшилтэт технологийг эзэмшинэ. Энэ бол хүндээ хийж буй маш том хөрөнгө оруулалт.

Ахин хэлэхэд Оюу толгой төсөл эдийн засгийн өсөлтийг дэмжих нь гарцаагүй. Гэхдээ хүлээж байгаа шиг өндөр өсөлт ойрын хугацаанд гарахгүй юм байна. ■

ЗЭЭЛ

ЭГИЙН ГОЛЫН ШИНЭ ТҮҮХ

Ц.Сайхан

БНХАУ-ын Экспорт-Импортын банкнаас нэг тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээл авч тодорхой төслүүдийг санхүүжүүлэх тухай асуудал “халуун” байлаа. Сөрөг хүчний зарим улс төрчийн хувьд энэ зээл нь эх орон, газар шороогоо алдахад хүргэх занга гэж хардаж байгаагаа ч нуусангүй. Хэдийгээр уг зээлийг оролцуулалгүй Засгийн газрын өр ДНБ-ий 58 орчим хувьтай тэнцэж байгаа ч хөнгөлөлттэй зээл авснаар Өрийн удирдлагын тухай хуулийг зөрчихгүй гэдэг тайлбарыг өгч байгаа билээ.

УИХ-ын гишүүн Н.Алтанхуяг уг зээлийн 80 гаруй хувийг зөвхөн нэг төсөлд зарцуулж байгаа нь буруу гэж үзэж буйгаа чуулганы хуралдаан дээр илэрхийлсэн. Түүнийг Ерөнхий сайд байх хугацаанд III, IV Дулааны цахилгаан станцын хүчин чадлыг нийт 173 МВт-аар нэмэгдүүлэхэд 110 сая ам.доллар зарцуулсныг хэлээд 800 гаруй сая төгрөгөөр 300 МВт хүчин чадалтай станц барьж байгаа нь ашиггүй гэсэн юм.

Өрийн удирдлагын тухай хуульд зааснаар “Нийгмийн үр өгөөжтэй, улсын төсөвт эргэн төлөгдөх

чадваргүй төсөл, арга хэмжээг нэн хөнгөлөлттэй зээлээр санхүүжүүлэх чиглэл баримтлах ба санхүүжүүлэх боломжгүй тохиолдолд хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлж болно” гэсэн нь бий. Үүнээс үзэхэд тус усан цахилгаан станцыг зардлаа эргэн төлөх чадваргүй гэх үндэслэл бий.

Эгийн голын усан цахилгаан станцыг барих төсөлд уг зээлийн хөрөнгөөс 703.5 сая ам.долларыг зарцуулна. Энэ нь төслийн нийт өртгийн 85 хувь, авч буй зээлийн 70.3 хувь юм. Ерөнхийдөө төслүүдийн нийт зардлын тус бүр 85 хувийг зээлээр



санхүүжүүлж байгаа юм. Зээлийн нөхцөлд “Инженер-худалдан авах-барих” төслүүдийн зээлээр санхүүжих хэсэг нь 50 хувиас багагүй, Тонго төхөөрөмж худалдан авах төслийн зээлээр санхүүжих зардал 65 хувиас багагүй гэсэн шаардлага тавьжээ. Зээлийн менежментийн төлбөр тэг хувь, зээлийн баталгааны төлбөр 0.25 хувь байна гэжээ. Хоёр хувийн хүүтэй зээлийг 20 жилийн хугацаатай авч байгаа. Эхний долоон жил үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөнө.

БНХАУ-ын дарга Си Зинь Пин өнгөрсөн жилийн наймдугаар сарын 21-нд манай улсад хийсэн айлчлалынхаа үеэр гурван жилийн хугацаанд 1.3 тэрбум юанийн буцалтгүй тусламж олгож, нэг тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээл олгохоо амласан юм. Харин энэ жилийн гуравдугаар сарын 9-нд Монгол Улсын засгийн газрын хуралдаанаар Эгийн голын усан цахилгаан станцыг уг хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр шийдвэрлэж хэлэлцээ эхлүүлсэн юм. Хэлэлцээрийг Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн өнгөрсөн сард БНХАУ-д хийсэн айлчлалын үеэр эцэслэж, талууд гэрээнд гарын үсэг зурсан билээ.

ЭГИЙН ГОЛЫН УСАН ЦАХИЛГААН СТАНЦ ТӨСӨЛ

2013 оны арваннэгдүгээр сарын 16-нд Монгол Улсын Засгийн газар Эгийн голын усан цахилгаан станцыг барих ажлыг эхлүүлэх шийдвэр гаргасан юм. Үүний дагуу “Эгийн голын УЦС-ын төслийн нэгж” байгуулагдаж тухайн оны арванхоёрдугаар сарын 2-ноос үйл ажиллагаа эхэлсэн байна.

Судалгаа шинжилгээний ажлууд явж шинэ техник, эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ) хийгдэж 2014 оны наймдугаар сарын 25-нд эрчим хүчний салбарын Шинжлэх ухаан, технологийн зөвлөлөөр дэмжсэн. Төслийн нийт өртөг 827 сая ам.доллар гэж тооцоолжээ.

Эгийн голын усан цахилгаан станцын урьдчилсан шатны дэд бүтцийн ажлыг Монголын тал хариуцаж байгаа бөгөөд нийт 98 сая ам.долларын ажлыг “Чайна Гэжүба групп лимитэд” компани концессын гэрээгээр гүйцэтгэх юм. Үүнд цахилгаан дамжуулах шугам, дэд станц, зам, гүүрийн ажил багтаж буй. Барилгын ажлыг 13 сарын дотор хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн байна. Энэ хугацаанд 500 гаруй ажлын байр бий болж, үүний 170 орчим нь монгол иргэн байх аж.

“Чайна Гэжүба групп лимитэд” компани нь эрчим хүчний салбарт, тэр дотроо усан цахилгаан станц, түүний дэд бүтцийг барих чиглэлээр дэлхийн шилдэг 50 компанид багтдаг, хөрөнгийн биржид бүртгэлтэй аж. Хөрөнгө оруулалтын газраас тус ажлыг өөрийн хөрөнгөөр гүйцэтгэх сонирхлоо илэрхийлсэн компаниудаас шалгаруулсан байна.

ЭГИЙН ГОЛ ЭДИЙН ЗАСАГТ

Эрчим хүчний төслүүд урт хугацаанд өгөөж өгдөг учир хөнгөлөлттэй зээлээр санхүүжүүлэх шийдвэр гаргажээ. Гэхдээ БНХАУ-аас олгож буй зээл нь урт хугацаат зээл учир Эгийн голын цахилгаан станц ажиллаж эхлээд олсон орлогоороо зээлийг барагдуулах боломжтой гэж

үзэх талтай. Зээлийг төлж дуусах хүртэл тус станцын үйлдвэрлэх нэг КВт цахилгаан 8.5 цент орчим үнэтэй байх бөгөөд зээлээ төлж дууссаны дараа 1.4-1.6 цент болж хямдрах юм. Ингэснээр Монгол Улсын хамгийн хямд эрчим хүч үйлдвэрлэгч болно. Өнөөдөр өрхийн хэрэглээний эрчим хүчний нэг КВт нь ойролцоогоор зургаан цент, (Уул уурхайн олборлох, боловсруулах аж үйлдвэр 13 цент, бусад аж ахуйн нэгж 10 орчим цент) байгаа бол сэргээгдэх эрчим хүчний хувьд 10 цент орчим байна.

Тус усан цахилгаан станц ашиглалтад орсноор Төвийн эрчим хүчний системийн тохируулга хийх, импортын эрчим хүчний хараат байдлаас гарах, найдвартай цахилгаан эрчим хүчний эх үүсвэр болох юм. Усан цахилгаан станцын онцлог нь эрчим хүчний тохируулгыг бага зардлаар, богино хугацаанд хийдэг явдал. Төвийн эрчим хүчний систем 2010 онд 157 сая КВт.ц эрчим хүч импортолжээ. Гэтэл төвийн бүсийн эрчим хүчний хэрэглээ улам бүр нэмэгдсээр байгаа билээ. Эгийн голын усан цахилгаан станцын суурилагад хүчин чадал 315 МВт, жилд дунджаар 606 сая КВт.ц цахилгаан үйлдвэрлэнэ гэж буй.

Улаанбаатар хотоос авто замаар 450 км гаруй зайд Булган аймгийн Хутаг өндөр сумын нутагт, Эг-Сэлэнгийн бэлчрээс дээш 2.5 км зайд Эгийн гол дээр барьж байгуулах уг станц 5.7 тэрбум шоо метр цэвэр усны сан үүсгэх юм. Энэ нь Монгол орны байгаль экологит сайнаар нөлөөлнө гэж үзэж буй. Гэвч үүнтэй холбоотой нэг асуудал бий болсон нь Эгийн голын цутгалт багасч Байгаль нуурын усны түвшинд нөлөөлөх сөрөг үр дагавартай гэж ОХУ-ын талаас үзэж буй. Ус зүйн болон бусад нөлөөллийн үнэлгээгээр Байгаль нуурт очих усны хэмжээ 0.020-0.023 хувиар багасна гэсэн тооцоо хийжээ. Энэ нь Байгаль нуурын усны түвшин болон экологит төдийлэн нөлөөлөх өөрчлөлт биш гэдгийг судлаачид хэлж буй. Дашрамд дурдахад Эгийн голд усан цахилгаан станц барьж болох тухай дүгнэлтийг 1965 онд ЗХУ-ын мэргэжилтнүүд гаргаж байжээ. Гэхдээ энэ асуудлаар ОХУ-ын талтай санал солилцож байгаа юм байна.

Эгийн голын усан цахилгаан станцаас гадна зээлийн санхүүжилтээр “Улаанбаатар-Мандалговь цахилгаан дамжуулах агаарын шугамаар холбох дэд станц барих” төсөлд 102.3 сая, “Эрдэнэтийн дулааны цахилгаан станц”-ыг шинэчлэхэд 40 сая, “Гачууртын уулзвараас Налайх-Чойрын уулзвар хүртэлх 20.9 км замын өргөтгөл, шинэчлэл” хийхэд зориулж

40,8 сая, мах боловсруулах 12 үйлдвэр барихад 66,2 сая, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдэд тоног төхөөрөмж нийлүүлэхэд 20 сая ам.доллар тус тус зарцуулах юм.

Эцэст нь тэмдэглэхэд, удаан жил яригдаж буй Эгийн голын усан цахилгаан станц төслийг урагшлуулахад дотоодод улс төрийн, Оросын талаас алтан хөршийнхөө

эрчим хүчний экспортоо алдахгүй гэсэн шахалт бий нь нууц биш. Харин нэг хөдлөх юм бол улсын эдий засагт ихээхэн ач холбогдолтой уг төслийг Хятадын нэг тэрбум ам.долларын зээл урагшлуулах нь тодорхой боллоо. Түүнчлэн бага гэлтгүй зээлийн үлдэж буй хувийг хэрэгцээтэй төслүүдэд зарцуулахаар байгаа нь сайшаалтай. ■

14 ХОНОГИЙН СЭДЭВ

Шинэ санаачилгатай ӨМЧ ХУВЬЧЛАЛ



Хуучнаар Сүхбаатарын нэрэмжит хэвлэх үйлдвэрийн байр нь хотын А зэрэглэлийн бүсэд байршилтай

Ц.Бадрал

Хэвлэх үйлдвэрийн барилга буюу хотын төвийн “А” зэрэглэлийн хамгийн сүүлчийн газрыг хувьчлах дуудлага худалдаа шуудхан хэлэхэд Монголын өмч хувьчлалд шинэ эргэлт хийлээ. Өнгөрсөн сарын 30-нд болсон дуудлага худалдаагаар 7.1 тэрбум төгрөгөөс эхэлсэн объект 24 тэрбум төгрөг хүрсэн юм. Гарсан амжилт зөвхөн үүгээр хязгаарлагдахгүй. Нэгдүгээрт, нээлттэй дуудлага худалдаа явуулснаар ашигтай

байрлалтай “балгас” болсон байр хэр үнэ хүрч, төсөвт орлого төвлөрүүлж болохыг. Хоёрдугаарт, Монголын дунд орлоготой иргэдэд үл хөдлөх хөрөнгө, санхүүгийн зах зээлд оролцох сонирхол хэчнээн их байгааг ганц өдрийн үйл явдал бодитоор харуулсан билээ. Тэгэхдээ үйл явдлын өрнөл хүлээж байснаас өөрөөр эргэж, олон нийтийн дунд асуулт болон хоцорлоо.

Тухайн өдөр уг барилгаас гадна “Автобус-3” НӨҮГ-ын барилга

байгууламжууд, Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын хуучин барилга, Өлзийт тосгоны дэд станц, Уурын зуухны дуусаагүй барилгыг дуудлага худалдаанд оруулахаар төлөвлөж байсан ч эдгээр объектийг худалдан авах хүсэлтэй нэгэн байсангүй. Ингээд болсон ганц дуудлага худалдаагаар үнэ цохиж ялалт байгуулсан Абдул Карим Забон хэл амнаас болоод ч тэр үү 24 тэрбумаар үнэлсэн газраа өмчлөхөөс

татгалзлаа. Чухамдаа, дуудлага худалдаа өндөрлөснөөс хойш төд удалгүй “Абдул Карим гэгч хэн бэ” гэдгийг хэвлэл мэдээллийн хэрэгслүүд тодруулахаар уралдан ажиллав. Одоогоор интернэт хайлтын “Google” системд дээрх өгөгдлийг оруулахад 119 мянган илэрц олдож байна.

Хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр түүнийг хууль бус шонхрын наймаа эрхэлсэн. Хэдийгээр 45 идлэг шонхор шувуу барих зөвшөөрөлтэй байсан ч 61-ийг барьсан, Катарын Батлан хамгаалахын сайдад 35 шонхор бэлэглэсэн зэргээр тодорхой бичиж, социал ертөнцөд байв. Харин тэрээр энэ бүх мэдээлэл цацагдсаны дараа ил захидал бичиж өөрийнхөө талаар мэдээлсэн бөгөөд хэвлэх үйлдвэрийн байрыг худалдан авах гэрээг цуцлахаа мэдэгдсэн юм. Тэрээр захидалдаа эхнэр Балжиннямтай 1996 онд гэр бүл болж гэрлэлтээ батлуулсан, 2002 онд албан ёсоор Монгол Улсын иргэн болсноо дурдаад, Монгол хонины ноос, өлөн гэдэс, монгол гэр зэргийг Европ Арабын зарим улс орнуудад экспортолдог гээд “Миний гэр бүлийн талаар ор үндэсгүй худал ташаа мэдээллийг цацаж байгаад харамсч байна. Дуудлага худалдаагаар “Улаанбаатар таймс” сонины хэвлэх үйлдвэрийн объектыг 24 тэрбум төгрөгөөр гадаадын хөрөнгө оруулалттайгаар худалдаж авах байсан боловч тодорхой хүндэтгэн үзэх шалтгаан Монголынхоо ард түмний санал хүсэлтийг хүндэтгэж энэхүү гэрээг цуцлах болно” гэжээ.

“Монголын ард түмэнд” гэж хаягласан түүний ил захидлын хариу мөн л социалаар түгэв. Улаанбаатар хотын захирагч Э.Бат-Үүл түүнд хандан “... Чухам таны шийдвэрийг юу ингэж өөрчилснийг мэдэхгүй юм. Хэрэв цахим сүлжээгээр тархсан элдэв үг яриа, социал ертөнцөд үзэл бодлоо илэрхийлсэн иргэдийн олон талын байр суурь таныг ийм шийдвэр гаргахад хүргэсэн бол туйлын харамсалтай байна... Монгол Улс бол ардчилсан орон. Хүн бүрийн үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх нь хуулиар баталгаажсан улс. Иргэд нь хэн нэгний харцаар 100 хувь нэг байр суурь илэрхийлдэг, эсвэл санаа бодлоо хэлэхээсээ айж эмээдэг

дарангуйллын нийгмээс хэдийнэ ангижирсан эрх чөлөөт орон” гэдгийг сануулсан байна.

Түүнчлэн Ард санхүүгийн нэгдлийн Гүйцэтгэх захирал Ч.Ганхуяг мөн Абдул Каримын захидал сошиалд тавигдсан даруйд мэдэгдэл хийсэн. Тэрбээр “... Хэвлэх үйлдвэрийн дуудлага худалдааны дараа хэд хэдэн хэвлэл мэдээллийн сувгаар ярилцлага өгөх үеэрээ болон хэвлэлийн бага хурал дээр би АЛИВАА хувьчлалд оролцогчийн жинхэнэ эзэн мөнгөний



Хэвлэх үйлдвэр хэнд очих бол гэдэг асуулт бий. Хуулийн дагуу хоёр дахь дээд үнийг хэлсэн хүн объектийг худалдан авах эрхтэй. Абдул Каримтай ширүүн өрсөлдөж 23.8 тэрбум төгрөгийн үнэ хэлсэн хүн бол “Таванбогд” группын захирал Ц.Баатарсайхан юм.



эх үүсвэр тодорхой байх ёстой гэдэг байр суурийг илэрхийлсэн. Буруу үг, хэллэг хэрэглэсэндээ хүлцэл өчье. Хувьчилсан хөрөнгийн эзэн нь ил, мөнгөний цаана ямарваа буруу гарын нөхөд байхгүй гэдгийг бид, Монгол Улс, баталгаажуулах ёстой гэдэгтэй та санал нэгдэх байх” хэмээжээ.


Ч.Ганхуягийн хувьд уг өмч хувьчлал болохоос дөрөв хоногийн өмнө өөрийн “Facebook” хуудаснаа “Улаанбаатар хотын хамгийн сайн байршилтай, Төрийн ордны баруун талын хэвлэх үйлдвэрийн газрын хувьчлалд иргэд оролцож яагаад болохгүй гэж. Иргэн бүр нэг сая төгрөгийг нэг дансанд төвлөрүүлээд 7.5 тэрбум төгрөг

бүрдүүлж болох юм” гээн санаачилга гаргасан нь даруй газар авч олон мянган хүн нэгдсэн билээ. Хэрэв ялалт байгуулбал оруулсан хөрөнгийн хэмжээгээр хувь эзэмших байв. Хэдийгээр иргэд идэвхтэй оролцсон ч цаг хугацааны хувьд давчуу байсан учраас дуудлага худалдааны заасан хугацаанд материалаа өгч амжаагүй. Гэхдээ зориглон хийсэн нь өөрийнх нь тооцоолж байгаагүй үр дүнд хүрсэн гэж Ч.Ганхуяг хэвлэлийн бага хурал зарлаж, мэдэгдсэн юм. Хэдийгээр тэрбээр нарийн тоог хэлэхийг хүсээгүй ч нэгэн ярилцлагадаа 4000 хүн санаачилгад нэгдэж мөнгөө шилжүүлсэн гэжээ. Тэрээр өөрт нь итгэж мөнгө шилжүүлсэн иргэдийг урамшуулах нь зүйтэй гэж үзэж тус бүр 20 ширхэг хувьцаа бэлэглэж байгаагаа хэвлэлийн бага хурлын үеэр хэлэв.

Хэдийгээр өрсөлдөөнд оролцож харахан амжаагүй ч энэ үйл явдал дуудлага худалдаанд зөвхөн хөрөнгө чинээтэй хүмүүс оролцдог юм биш, монголчууд нэгдэн нийлбэл ялалт байгуулж хувьцаа эзэмших боломж бий гэдгийг нотлон харуулж чадсан. Ч.Ганхуягийн энэхүү санаачлагыг сайшааж Хөрөнгийн биржийн гүйцэтгэх захирлын албан тушаалыг хашиж байсан Д.Ангар ирэх онд хувьчлагдах Хөрөнгийн биржийн хувьчлалд дээрхийн адил иргэдийн оролцоог хангаж, бэлтгэлтэй оролцох санаачилга гаргаад байгаа. Д.Ангарын хувьд ижил зорилготой иргэдийн хамтаар “Novel fund” гэгчийг үүсгэн байгуулаад байна.

Одоо олон нийтийн дунд хэвлэх үйлдвэр хэнд очих бол гэдэг асуулт үлдлээ. Хуулийн дагуу хоёр дахь дээд үнийг хэлсэн хүн объектийг худалдан авах эрхтэй. Абдул Каримтай ширүүн өрсөлдөж 23.8 тэрбум төгрөгийн үнэ хэлсэн хүн бол “Таванбогд” группын захирал Ц.Баатарсайхан юм. Түүнд Абдул Карим хуулийн хугацаанд мөнгөө шилжүүлэхгүй бол худалдан авах боломжтой гэсэн хүсэлтийг Нийслэлийн өмчийн харилцааны газраас хүргүүлжээ. Хэрэв тэрээр зөвшөөрөхгүй бол дахин дуудлага худалдаа зарлах юм. Гэхдээ Абдул Каримд мөнгөө шилжүүлж, хэвлэх үйлдвэрийн барилгыг худалдан авах хугацаа байгаа аж. ■

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ



Сүүдрээс урьтаж

Г.Орхон

Монголыг дэлхийд таниулдаг гол “мессежүүд”-ийн нэг хаалгаа түгжинэ гэдгийг мэддэггүй уужим сэтгэлт, эрх чөлөөт талын эзэд юм. Энэ нь шууд утгаараа аюулгүй орон гэсэн үг. Хаана ч аялал жуулчлалын салбарын гол зүйлийн нэгт аюулгүй байдал тооцогддог. Тэгвэл тухайн улсын аюулгүй байдлын нүүр царай нь Нийслэл, тэнд амьдарч буй иргэд юм. Монгол Улс энэ асуудлаар толгой өвдөхгүй суух орон биш ч хэдий анхаарал тавиад эхэлжээ.

Жилийн 250 өдөр нартай байдаг тийм л цэлмэг тэнгэрийг харах гэж өнгө өнгийн “толгойтой” хүмүүс Монгол Улсыг зорьдог. Энэ тухай манай улсад хөл тавьсан жуулчдын нэг CNN агентлагийн сэтгүүлч Нила Свиней аяллын тэмдэглэлдээ онцолж. Түүний тэмдэглэсэн шиг хэдэн зуун км газарт нэг ч хүн, амьтантай тааралддаггүй “эзэнгүй” эрх чөлөө, тэнэгэр нутаг бидэнд бий. Чухам үүнээс эхлэлтэй тал нутгийг үзэхийн сайхныг бодон ирж, сэтгэл хоргодон буцдаг нь жуулчид. Гэвч тэд нийслэл хотод

саатахыг төдийлэн таашаадаггүй.

Гаднын жуулчдын хувьд Монгол дахь анхны өртөө Улаанбаатар хот. Тиймээс өөдлөх айл үүднээсээ хэмээн хотын нүүрийг угаах тал дээр Нийслэлийн захиргаа болон улсын зүгээс анхаарахгүй биш анзаарч буй. Нөгөө талаас, жуулчдын аюулгүй байдлыг хангах тал дээр хэрхэн ажиллаж буй нь жуулчдад их чухал. Гэхдээ Монголын хувьд жуулчдынхаа аюулгүй байдалд анхаарал тавихаас илүүтэй тэд өөрсдөө амь нас, эрүүл мэнд болон эд зүйлсээ датгуулахдаа илүү их мөнгө төлж ирдэг гэдгийг “Нью Жуулчин” “болон Overseas Adventure Travel” компанийн хөтөч, орчуулагч Б.Мөнхнаран ярьсан. Гэхдээ жуулчны компаниуд болон аяллын хөтөч нар жуулчдад тулгарч болзошгүй асуудлын талаар үргэлж анхааруулахаа мартдаггүй. Энэ нь хотын аялал жуулчлалын аюулгүй байдлын өнөөгийн үнэн төрхийг гайхаад байх зүйлгүйгээр шуудхан илтгэж байгаа юм.

Манай улсад саатаад буцсан

жуулчдад монголчуудын зочломтгой зан сайхан сэтгэгдэл төрүүлдэг ч их хотод тохиолдсон зарим таагүй явдал айдсыг ч мөн тэдэнд тээлгэдэг нь үнэн. Үүнийг адал явдал гэж харах хэсэг байхад аяллыг нь сүйрүүлсэн хар дурсамж гэж харах нөгөө нь ч бий. Жуулчдын сэтгэл ханамжийн талаарх судалгаанаас үзэхэд хулгай, дээрэм, гудамжинд залуу эмэгтэй жуулчидтай эвгүй харьцдаг зэрэг нийгмийн асуудлууд нэлээд таагүй сэтгэгдэл үлдээжээ. Хөгжиж буй орнуудын адил манайд дэд бүтцийн асуудлаас үүдэн тэдний аюулгүй байдал алдагдах тохиолдол багагүй гардаг. Үүнд, явган хүний зам муугаас болж унаж бэртэх, хотын замын зарим гэрлэн дохионы учрыг ойлгож зам гарна гэдэг амаргүй. Тухайлбал, ногоон гэрэл ассан байхад зам хөндлөн гарч буй явган зорчигчын зүүн гар талын урсгал зогсдоггүй, давхацдаг. Үүнээс гадна жуулчдын хувьд таксины жолооч хадны мангаа мэт ойлголт төрүүлэхийг үгүйсгэхгүй. Яагаад гэвэл тэд хэл нэвтрэлцэхгүй гадаад хүн битгий хэл, монголчуудаа

болж өгвөл монжчих гээд байдаг улс. Эдгээр нь зөвхөн манайд байдаг биш, буурай орнуудад аялж буй жуулчдад иймэрхүү асуудал багагүй тохиолддог аж.



Аялахад хамгийн аюултай хотуудын жагсаалтыг тэргүүлдэг Мехико, Кракас зэрэг хоттой харьцуулахад Улаанбаатар харьцангуй тайван. Ялангуяа, байгалийн гамшиг, зэвсэгт мөргөлдөөн тасардаггүй хотуудын хажууд аюул багатай. Гэсэн ч дээр дурьдсанчлан тоолгүй орхиж үл болох асуудал байсаар. Монголд жуулчдын аюулгүй байдлыг хангах талд анхаарсан зүйл тун хомс байгаа тухай хөтөч, орчуулагчид хэлдэг. Харин тэд оюутан цагдаа нар ажиллуулдаг болсныг олзуурхаж байна. Цаашид жуулчид их явдаг газруудад ийм төрлийн үйлчилгээ үзүүлдэг цагдааг олноор ажиллуулах хэрэгтэй гэв. Нийслэлийн Аялал жуулчлалын газраас хотын Цагдаагийн газар болон Монголын оюутны холбоотой хамтран “Оюутан цагдаа” хөтөлбөрийг хоёр дахь жилдээ зохион байгуулжээ. Оюутнууд өдрийн зургаан цагаар, зуны гурван сарын турш ажилласны үр дүнд гэмт хэрэгт өртөж хохирсон гадаад иргэдийн тоо өмнөх оныхоос 18.4 хувиар буурчээ. Энэ бол “Tourist guide police” гэх бичигтэй ногоон өнгийн өмсгөл, улбар шар малгайгаар жигдэрсэн залуусын ажлын шим.

Харин дэлхийн зарим улс оюутан цагдаа гэхээс илүүтэй жуулчдад зориулсан цагдаагийн төвтэй байдаг. Аялахад хамгийн аюултай хотуудын жагсаалтын дээгүүрт ордог Мексикийн Мехико хотод жуулчдад яаралтай түргэн тусламж үзүүлэх “Жуулчны цагдаа” гэх төв бий. Ер нь ийм төрлийн тусгай цагдаа ОХУ, Малайз, Израиль, Тайланд зэрэг оронд байдаг аж. Харин манай улсын энэ жил л анх удаа Улаанбаатар хотын Цагдаагийн газрын дэргэд жуулчны цагдаагийн

бие даасан нэгж байгуулсан. Угтаа тус нэгж нь урьд нь ярих төдий өнгөрдөг байсан жуулчдын аюулгүй байдалтай холбоотой олон асуудлыг шийдэх үүрэгтэй аж. Харин одоо энэ нэгжийг бэхжүүлэх, цаашлаад өдгөө жуулчид тогтдоггүй хотыг “хоргоддог хот” болгох үүднээс тууштай ажлууд хийх хэрэг бийг салбарынхан хэлж байна. Тэр дундаа, жуулчдыг таагүй сэтгэгдэлтэйгээр үдэхэд хүргэж буй дэд бүтцийн асуудлуудыг сайжруулах нь тэргүүний ажил.

Бусад хот жуулчдынхаа ая тухыг өндөрт тавин, тэдний аюулгүй байдлыг хангахын тулд онцгой анхаарч байна. Харин манай улсын хувьд салбарын яамны хэдэн мэргэжилтэн Нийслэлийн Аялал жуулчлалын газар багагүй ажил хийсэн гэхээс өөрөөр жуулчны аюулгүй байдлын талаар хэлчихээр зүйлгүй сууна. Нийслэлийн аялал жуулчлалын газрынхан энэ чиглэлээр хэлж яриад байх ажил багагүй хийжээ. Тухайлбал, жуулчны мэдээллийн төвийг гурван салбартайгаар ажиллуулдаг болж, нийслэл дэх үйлчилгээний байгууллагуудын мэдээллийг “Google Map”-д оруулжээ. Мөн жуулчин тээврийн автобусуудыг улсын дугаарын хязгаарлалтаас чөлөөлж, 500 гаруй автобусанд тээврийн зөвшөөрөл олгосон бөгөөд тэдэнд зориулан тусгай зогсоолуудыг ч бий болгосон байна. Энэ нь бусад хотод аль хэдийн хийчихсэн ажил. Бид жуулчдын аюулгүй байдлыг хангах талд харьцангуй орой хөдөлж буй орны нэг. Үүнийг батлах мэт Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яамнаас Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг Засгийн газарт өргөн барихаар ажиллан түмэн завгүй байгаа гэв. Тус яамны Аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газрын дарга Б.Маргад “Аялал жуулчлалын тухай хуулинд маш олон шинэчлэл хийх шаардлага байгаа учир шинэчилж байна. Хуулийн шинэчилсэн найруулга дахь зүйл заалтуудын 50 орчим хувь нь жуулчны аюулгүй байдлыг хангахад чиглэж байгаа” гэсэн юм. Уг хуулийн шинэчилсэн найруулгыг баталсны дараа тэрбээр жуулчны аюулгүй байдлыг хангах талаарх яамны байр суурийг дэлгэрэнгүй хэлнэ

гэлээ. Манай улс Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрөө энэ оны долдугаар сард баталсан. Харин тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээнд жуулчны аюулгүй байдлыг хангах ганцхан заалт оржээ. Сийрүүлбэл, хөтөлбөрийн 4.1.3 заалтад “Жуулчид ая тухтай, аюулгүй зорчих нөхцлийг бүрдүүлэх...” хэмээн тусгаж. Эндээс аюулгүй байдлыг огт анхаараагүй биш анзаарч буй нь харагдаж байгаа юм. Гэхдээ хэрхэн, яаж гэдэг нь тодорхойгүй. Нөгөө талаас, энэ нь яамныхныг ажлаа хийх боломж олгохгүй, ийш тийш нь хэдэн яамны хормой руу шидэж ирсэнтэй холбоотой ч байж болох. Угтаа бол бодит ажил жуулчдад өгөөжтэй.

Жуулчдын аюулгүй байдал алдагдсан нэгэн баримт дурьдая. Энэ оны дөрөвдүгээр сард “Хөх Монгол” бүлгийнхэн Бурхан Халдун ууланд аялж явсан Өвөрмонгол жуулчдад халдсан хэрэг. Тухайн үед, үүнд Нийслэлийн зүгээс анхаарч, Хотын дарга холбогдох жуулчдаас уучлалт хүссэн билээ. Гэвч жуулчдад учирсан асуудал бүрийн араас хэн нэгэн удирдлага энэ мэтчилэн уучлалт гуйгаад явахад асуудалтай учир үүнд тохирсон тогтолцоог бий болгох шаардлагатай гэсэн үг. Харин хот энэ жилээс аялал жуулчлалын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөтэй болох гэж байгаа аж. Тус төлөвлөгөөнд нь үер, газар хөдлөлт зэрэг онцгой болон эрсдэл бүхий нөхцөлд жуулчдын аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх, авран хамгаалах арга замуудыг тодорхойлжээ.

Жуулчны аюулгүй байдлыг хангахад учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх нь хамгийн чухал ажил. Үүнийг Нийслэлийн Аялал жуулчлалын газрынхан ямартай ч олоод харж. Харин өдгөө Монголыг харьцангуй тайван гэж тайвширч суух биш, нийслэлийн зүгээс ч, салбарын яамны зүгээс ч санаа тавьж, хамтран багагүйг хийх хэрэгтэй болов уу. Нөгөө талаас, жуулчдад ээлтэй, тайван хот болоход нийслэлд амьдарч буй иргэн бүрийн найрсаг оролцоо чухал. Эс тэгвээс аялахад хамгийн аюултай хотуудын жагсаалтын дээгүүрт орж, хусаад ч арилахгүй хар толботой болох вий дээ. ■



ҮЗЭЛ БОДОЛ

Шчоошиг



Д.Жаргалсайхан
/Уул уурхайн эдийн засагч/

Марзан гарчиг вэ гэж хүн болгон хэлэх л байх. Та бидний өдөр тутам хэрэглэдэг үг шүү дээ. Уг гарал нь бол счетчик хэмээх орос үг. Шчоошиг бол бидний монголчууд машина гэдэг орос үгийг машин, мотор хэмээх орос үгийг мотоор, крыло хэмээх орос үгийг хярлаа, коробка гэдэг үгийг хроп гэх мэт шууд монгол үг болгоод ашигладагтай адил тоолуур хэмээх утгатай орос үгийг шууд монголчилж дуудаж байгаа хэрэг. Бидний ахуйд хэрэглэсэн цахилгааны үнийг төлөхөд хэрэглэгч, нийлүүлэгч хоёрыг маргашгүй тоогоор эвлэрүүлж, нэгэн ойлголтод хүргэж өгдөг ачтай эд. Шчоошиг байхгүй бол мөн ч их хэрүүл маргаан гарна даа. Мөн бидний хэлж заншиснаар цахилгааны мөнгийг задгайгаар буюу шчоошиггүй авах болохоор маргаан, авилгал хоёр сүүдэр мэт дагах нь мэдээж.

Энэхүү нийтлэлийн эхэнд тоолуурын тухай бичих болсон нь дараахи учиртай.

Саяхан надад Монгол Улсын урт хугацааны тогтвортой хөгжлийн үзэл баримтлал нэртэй бичиг баримтын хэлэлцүүлэгт оролцоно уу гэсэн урилга ирсэн юм. Уг хэлэлцүүлгийг УИХ-ын Төрийн байгуулалтын Байнгын хорооноос санаачилан Төрийн ордонд хийсэн. Хэлэлцүүлэгт манай улсын өмнөө барьдаг судлаачид, шинжээчид төдийгүй хувийн хэвшлийн төлөөлөгчдийг урьж оролцуулсан нь ажиглагдлаа. Тэгээд манайхан бас аливаа шийдвэрийг гаргахын өмнө иргэдтэйгээ зөвлөлддөг зөв жишгийг тогтоох гэж байгаа юм байна гэж ойлгосон. Өөрсдийнх нь гаргасан санаачилга, төслийг эсэргүүцээд унагачихаж магадгүй хэмээн айж болгоомжлохдоо сэмхэн, далдуур

шийдвэр гаргачихдаг муу зангаа засаж байгаа юм уу даа. Жаахан жаахан засарч байна аа.

Уригдаж оролцсон хүмүүс янз бүрийн санаа оноонууд хэлж байна, бас бухимдалтай хүмүүс ч байгаа нь анзаарагдлаа. Хэлэлцүүлгийн үеэр тараасан материалтай танилцаж үзвэл тэнд байсан, оролцсон зарим хүмүүс яагаад бухимдаад байгааг ойлгож болохоор байна. Ардчилсан нийгэм юм чинь тийм юм байлгүй яахав, бас тэгээд хүн болгонд таалагдсан тийм төгс төгөлдөр ямар ч юмыг өнөөдрийг хүртэл хүн төрөлхтөн бүтээж чадаагүй юм чинь .

Хэлэлцүүлгийг санаачлагчдын хэлсэн үг, тайлбарт нээлттэй нийгмийн зарчимд нийцсэн, нааштай дүгнэлтүүд гарснаас заримыг нь дурьдая:

-Уг төслийн баримт бичгийг боловсруулах ажлын хэсгийг

Парламентад суудалтай бүх улс төрийн намуудын болон бие даагчдын төлөөллийг оролцуулан байгуулсан

-Төслийн баримт бичгийг ажлын хэсэг санал нэгтэй дэмжиж байгаа

-Энэхүү бодлогын баримт бичигт тусгасан зорилтуудыг хэрэгжүүлэх / албадлагын гэж би тодорхойлж байгаа юм/ механизмыг нэгэнт бий болгосон, өөрөөр хэлбэл , энэхүү үзэл баримтлалыг албадан хэрэгжүүлэх хуулийг нь урьдчилан баталж гаргасан.

-Зорилтуудад хүрсэн эсэхээ шалгах тоон хэмжүүрүүдийг сонгож тодорхойлсон.

-Олон нийттэй нээлттэй хэлэлцүүлгүүдийг олон удаа зохион байгуулна .

Дээрх дүгнэлтүүдээс харвал энэ удаагийн бодлогын баримт бичгийг нэлээд ул суурьтай боловсруулсны зэрэгцээ аль болох зөвшилцөлийн замаар шийдлүүдээ бий болгохыг зорьсон сайн талтай.

Уг баримт бичигт өгсөн нэр нь / Монгол Улсын урт хугацааны тогтвортой хөгжлийн үзэл баримтлал / олон олон хүнийг төөрөгдүүлж, бухимдлыг нь төрүүлж байгаа бололтой. Нэг бол нэр нь уг баримт бичигт тусгагдсан ажлынхаа агуулгатай нийлэхгүй байгаа эсвэл нэр нь хэт өргөн хүрээг хамарсан байгаагаас уг баримт бичгээр тодорхойлох ёстой асуудлууд нь бас их өргөн хүрээтэй, ерөнхий болжээ. Тийм учраас хэдэн ч удаа хэлэлцүүлэг хийсэн нэгдсэн ойлголтод хүрэх боломжгүй төдийгүй үүний улмаас цаашдын хэрэгжүүлэх үйл ажиллагаанд үлэмж саад тотгор учирч болзошгүй юм. Ажлын хэсгийнхэн анхааралдаа авна биз дээ.

Хэлэлцүүлэг хийхэд учир бий. Маш тодорхой зорилго тавилгүйгээр ийм өргөн цар хүрээтэй, ерөнхий асуудлаар хэлэлцүүлэг хийвэл үр дүнгүй болох төдийгүй хэлэлцүүлэг биш хэрүүл уруул болоод дуусдаг муу талтай. Хөндлөнгийн нүдээр харвал иймэрхүү сул талууд харагдаж байна.

Гэвч энэ бол Монгол Улсын ирээдүйн хөгжилд маш том дэвшил авчрах чухал ажлын эхлэл тавигдаж байна гэж би үзэж байгаа юм.

Тэртээ 1990 онд монголчууд бид тайван замаар хувьсгал хийж хуучин нийгмээ халж шинэ , таньж мэдэхгүй

нийгмийн тогтолцоог сонгосон билээ. Тэгэхдээ бид сонгосон тогтолцоогоо сайн мэддэг учраас өнөөгийн нийгмийн тогтолцоог сонгосон биш харин хуучин нийгэм маань болж бүтэхгүй байсан учраас шинэ нийгмийн тогтолцоог сонгосон. Тэрхүү сонгосон нийгмийнхээ үнэт зүйлс нь чухам юу вэ ? тэр үнэт зүйлсийг юугаар яаж хэмжих вэ? гэдгийг тэр үедээ бидний хэн маань ч мэддэггүй, мөнгө гэдэг хэмжүүрээр бүхнийг хэмждэг нийгэм хэмээн сэтгэж бүгдээрээ баяжихаар явган нь явганаар, морьтой нь мориороо , машинтай нь машинтайгаа баахан таваргасан.

Ингээд 25 жилийн дараа нэг амсхийгээд эргээд харсан чин зарим нь мөнгөтэй, хөрөнгө чинээтэй амьдралтай болсон байхад зарим нь ядуу хоосорсон, ядмагхан амьдралтай өдрийг өнгөрөөж байх юм. Харин хамгийн эмгэнэлтэй нь мөнгөтэй, чинээлэг иргэдийн дунд ч, ядуу тарчиг амьдралтай иргэдийн дунд ч жинхэнэ аз жаргалтай хүн байдаггүй. Байгаа ч байж магадгүй. Байгаа бол тэдний тоо лав л их цөөхөн. Учир нь үргэлж л сэтгэл дундуур, түгшүүртэй , ууртай , уцаартай хүмүүс тааралдах юм. Сэтгэл сэртхийм гэмт хэрэг , байгалийн гамшиг олонтаа тохиож байна. Гэтэл бидний зарим маань тэдний дотор улс төрөөр дагнадаг хэсэг маань амьдрал сайхан болж байна, ийм зүйлийг бүтээлээ, хүмүүс баяжиж байна, тийм тууз хайчиллаа гээд л өөрсдийгөө магтан дуулж байхад нөгөө хэсэг нь ийм зүйлийг хийсэнгүй, тийм зүйлийг хийсэнгүй, ядуу иргэдийн тоо олширлоо, амьдрал муудаж байна хэмээн шүүмжлээд эцэс төгсгөлгүй маргаанаар манийхаа тархийг эргүүлсээр байна.

Сүүлдээ бүр коммунизм, социализм руугаа буцаж орохыг мөрөөддөг, хүчтэй хатуу гар үгүйлдэг, уриалдаг хүмүүсийн тоо олширч улмаар ард иргэдийн нэрийн өмнөөс буу зэмсэг агсах, өөр дээрээ бензин асгах гэх мэтээр өөрсдийнхөө хэт даварсан үйлдлүүдээр нийгэмд өөрсдийнхөө сайн, муугийн шалгууруудыг тулгахыг оролдох боллоо. Ийм их маргаан мэтгэлцээнээс иргэд залхаж, бас улс төрчдөд, бие биендээ , ирээдүйдээ итгэх итгэл алдарч байгаа нь нууц биш.

Эдгээр байдлыг залруулах, улмаар эрүүл саруул ухаанаар өмнөө тулгарсан сорилтуудыг даван туулах арга замаа тодорхойлох шаардлага та бидний өмнө тулжээ. Энэ ажлыг та биднээс өөр хэн ч бидэн шиг сайн мэдэхгүй учраас өөр хэн нэгэн мэргэн бөөдий ирж биднийг зовлон, бэрхшээлээс маань салгаж өгөх болов уу гэж горьдон суух нь бүр ч эмгэнэлтэй байдалд хүргэнэ.

Юунаас эхэлбэл зохистой вэ? Хүмүүсийг хоёрхон зүйл л нэгтгэдэг гэдэг. Нэг нь айсуу яваа аюулаас айх айдас, нөгөө нь нэгдсэн зорилго. Та бид энэ нийгмийн нэгээхэн эд эс болж , бие биентэйгээ харилцаанд орж байгаа бол ямар нэг зорилго та биднийг нэгтгэж байна гэсэн үг.

Нийгэмд маань зорилго гэж юм байна уу ? Байна аа. Үндсэн хуулиндаа Эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлоон хөгжүүлэх гэж нийгмийн зорилгоо тодорхойлсон байдаг. Тэгвэл хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм гэж ямар нийгмийг ойлгох вэ ? Одоо болтол энэ асуултад нийгмээрээ хүлээн зөвшөөрсөн хариултыг манай эрдэмтэн , судлаачид, улс төрчид судалж тодорхойлоогүй , нээлттэй хэвээр байгаа юм. Ийм бүрхэг, тодорхойгүй байгаа нь манай улстөрчид, намууд, популистууд тийм байдлыг маш чадамгай, овжин ашиглаж , иргэдийн итгэл найдвараар удаа дараа тоглох боломжийг олгоод байгаа нь ойлгомжтой. Ийм л нөхцөл байдлыг залруулах гэж дээрх бодлогын баримт бичгийг боловсруулсан болов уу. Олон олон шүүмжлэх зүйлүүд байгаа ч энэ удаагийн бодлогын баримт бичгийг миний бие бүрэн дүүрэн дэмжиж байгаа төдийгүй, дэмжиж өгнө үү хэмээн иргэдийг уриалж байна.

Энд зарчмын чухал ач холбогдолтой нэг шийдэл байгаа нь нийгмийн хөгжлийг хэмжих шчоошиг буюу тоолууруудыг бий болгож, түүнийгээ хөгжлийн бодлого төлөвлөлтийн бүх түвшинд хэрэглэхээр болж байгаа явдал юм. 25 үзүүлэлтүүдийг сонгожээ:

Эдгээр үзүүлэлтүүдээр нийгмийн хөгжлөө, нийгмийг хөгжүүлэх ажлаа хэмжинэ гэсэн үг. **Жишээлбэл:** Намуудын сонгуулийн мөрийн хөтөлбөр, Засгийн газрын

-Эдийн засгийн жилийн дундаж өсөлт
 -Нэг хүнд ноогдох үндсэний нийт орлого
 -Хүний хөгжлийн үзүүлэлт
 -Дундаж наслалт
 -Жини коэффициент
 -Ядуурлын түвшин
 -Инновацийн хөгжлийн үзүүлэлт
 -Хүнсний баталгаат байдлын үзүүлэлт
 -Өрсөлдөх чадварын үзүүлэлт
 -Эдийн засгийн эрх чөлөөний үзүүлэлт
 -Засаглалын үзүүлэлт
 -Бизнес эрхлэлтийн үзүүлэлт
 -Байгаль орчны багц үзүүлэлт
 -Нийгмийн даатгалд хамрагдсан хүн амын эзлэх хувь
 -1000 амьд төрөлт дэх нялхасын эндээдлийн түвшин

-100000 амьд төрөлт дэх эхийн эндээдлийн түвшин
 -ЕБС-ийн анги дүүргэлт
 -Олон улсын хорио цээрт нээлттэй болсон газар нутгийн эзлэх хувь
 -Цөлжилтөнд өртсөн газар нутгийн эзлэх хувь
 -Монгол улсад аялах гадаад жуулчдын тоо
 -Цахилгаан эрчим хүчний найдвартай эх үүсвэрээр хангагдсан хүн амын эзлэх хувь
 -Нийт экспортод боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувь
 -ДНБ-д боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувь
 -Гол нэр төрлийн шатахууны хэрэгцээг дотоодын эх үүсвэрээс хангах хувь

өргөн хэрэглэгддэг болно. Адаглаад л худлаа амлалт өгсөн эсэхийг нь бид маргаангүй тогтоож чаддаг болно. Ингэж чадвал таньдаг хүндээ биш худлаа ярьдаггүй хүнд саналаа өгөх үндэслэлтэй болно.

Дээрх сонгож авсан үзүүлэлтүүд хамгийн зөв, оновчтой гэж хэлж чадахгүй боловч тэр нь өнөөдөр чухал биш. Тэр ч битгий хэл тэр Үзэл баримтлалын баримт бичигт тодорхойлсон олон тунхаг, зарчмууд өнөөдөр чухал биш. Бусад олон хөтөлбөрт тусгадаг шиг дээрх тоон үзүүлэлтээр тодорхойлсон зорилгодоо хүрэхэд ашиглах мөрөөдлийн жагсаалт шиг олон арга замуудтай би санал нийлэхгүй байна. Тэр нь өнөөдөр чухал биш байна. Харин хэн ч маргахгүй албан ёсны тоон үзүүлэлтээр хөгжлөө, нийгмээ хэмждэг болох гэж байгаа нь л өнөөдөр их чухал. Үзүүлэлтүүдийн тоо, хэлбэр яваандаа өөрчлөгдөнө, сайжирна. Ямар ч эргэлзээгүй. Энэ сайн эхлэлийг бүгдээрээ дэмжиж ажил хэрэг болгоё. Сайн үйлс бүхэн дэлгэрэг, хүмүүсээ. ■

мөрийн хөтөлбөр, Засгийн газрын байгууллагуудын ажлын үр дүн гээд хөгжлийн бодлогын төлөвлөлттэй холбоотой бүхий л ажлууд, түүний үр дүн нь дээрх хэмжүүрүүдээр хэмжигдэж шалгагдана. Аль ч намын дарга засгийн эрх барьсан ажлын үр дүнгээ дээрх үзүүлэлтүүдээр

тайлагнадаг болно. Шүүмжлэгч нар ч гэсэн мөн адил мөнөөх үзүүлэлтүүдээр Засгийн газрыг, өрсөлдөгч нараа шүүмжилнэ. Дээрх үзүүлэлтүүд нь зөвхөн улстөрчид, төрийн байгууллагуудад хамаатай юу гэвэл бас тийм биш. Энэ бол иргэн та бидний өдөр тутмын амьдралд ч мөн

Редакцид захиалбал хүргэлт үнэгүй

Харилцах утас:
94092904, 88006228,
70115476, 70115477

marketing@mongolianeconomy.mn
info@mongolianeconomy.mn





ӨДРИЙН СУРВАЛЖЛАГА

Хямрал дагасан хямдрал

Г.Орхон

Манай улсын эдийн засаг энэ оны гуравдугаар улирлын байдлаар 2.5 хувийн өсөлттэй гарсан бол оны эцэст дахин буурах хүлээлтийг бий болгоод буй. Өнгөрсөн жилийн мөн үед долоон хувь болж өмнөх оныхоос огцом саарсан эдийн засгийн өсөлт байнга уруудсаар. Энэ байдал ард түмний амьдралд хүндрэл бий болгосоор.

Өргөн хэрэглээний барааны үнэ нэмэгдсээр байна. Харин худалдаа наймаа эрхлэгчдийн хувьд валютын ханш нэмэгдэж байгаа ч барааны эргэлтээ бодон аль болох бага үнээр худалдаалж байгаа гэх. Харин олзуурхах зүйл гэвэл хаа сайгүй "Sale" гэсэн том бичиг өлгөөтэй. Хямрал бодит хямдралыг бэлэглэж буй нь Монголд шинэ зүйл. "Номин", "Макс молл" тэргүүтэй томоохон худалдааны төвүүд хямдрал, урамшууллаар бусдыгаа уриалан, "Black Friday" гэх барууны худалдааны соёлыг эх орондоо нэвтрүүлж байна. Их хотын худалдааны төвүүдээр явж байх зуур Сүхбаатар дүүргийн дөрөвдүгээр хорооны иргэн Д.Туяа "Хаа сайгүй хямдрал байна. Би сая "Yves Rocher" брэндийн дэлгүүр ороход ихэнх бараа

нь 20-50 хувь хямдарч. Ер нь гадуур хямрал дагасан хямдрал их байна" хэмээн ярилаа.

"Макс Молл" их дэлгүүрт сарын өмнөөс хямдрал эхэлж. Өнгөрсөн сарын 27-29-нд бүх бараандаа хямдрал зарласан бөгөөд хямдралын дээд хэмжээ 70 хувьд хүрсэн. Тухайн үед энгийн үеэсээ худалдан авагчдын тоо хоёроос гурав дахин нэмэгдсэн төдийгүй, иргэд ч худалдан авалт багагүй хийсэн тухай тус дэлгүүрийн мэдээллийн ажилтан хэлсэн. Харин "Номин Юнайтед" их дэлгүүрт өнгөрсөн сарын 26-ны шөнийн 22-02 цагийн хооронд "Black Friday" худалдааг зохион байгуулав. Энэ үеэр тэд цахилгаан болон гэр ахуйн тодорхой бараанууддаа хямдрал зарласан бөгөөд тус дэлгүүрийнхэн хөл ихтэй байсан тул уг арга хэмжээг дөрөв хоног сунгажээ. Гэтэл зарим дэлгүүр, тэр дундаа лангуу түрээслэгчид үйл ажиллагаагаа зогсоож сүүлчийн хямдралаа зарлаж буй нь харамсалтай.

Иргэд хямралтай үед олсон хэдээ хямд зүйлст зарцуулж, хэрэглээгээ хумихыг эрхэмлэх болж. Угтаа эдийн

засгийн хүнд байдлыг хуримтлалтай хүмүүс санхүүгийн хувьд дарамт багатайгаар туулах боломжтой. Гэвч манай улсын нийт өрхийн 90 хувь нь хадгаламжгүй гэх статистик бий. Хуримтлалтай хүн зад болон задгай хямдралыг далимдуулж өмнө нь "шүлс гоожуулан" өнгөрдөг байсан үнэтэй брэндийн барааг сэтгэлдээ нийцсэн хямд үнээр худалдан авч сэтгэл өөдрөг гэртээ харих боломж олдож байна. Товчхондоо, хямралтай байдал монголчуудад хуримтлалын тусыг ойлгуулж буй.

ХООСОН ЛАНГУУ, ХОЁР ГУРАВХАН ХҮН

Худалдааны бизнес эрхлэгчдийн хувьд импортын үнэтэй хувцас хунар зэрэг бараандаа хямдрал зарлаж орлого олж байхад үндэсний үйлдвэрлэлийн бараа бүтээгдэхүүн борлуулагчдын хувьд зарим газар лангуугаа хураахад хүрч байгаа аж. Тухайлбал, энд Шөнийн захыг дурьдаж болно.

Хэдхэн жилийн өмнө хөл гишгих зайгүй, түм түжигнэдэг байсан тус захын босгыг давтал хоосон



лангуунуудын дунд холхисон хоёр гуравхан хүн угтав. Бизнес эрхлэгчдийн орлого багасч, улмаар тус зах ийн эл хуль болжээ. Үндэсний үйлдвэрлэлийн худалдааны төв гэх тодотголтой тус захын гуравдугаар давхар тэр чигээрээ, хоёрдугаар давхрын бараг 80 хувь нь хоосон. Харин нэгдүгээр давхрын лангуунуудын 70 хүрэхгүй хувийг нь дотоодын болон импортын бараагаар дүүргэж. Уг нь өнгөрсөн онд салбарын яамны дэмжлэгээр тус захын нэгдүгээр давхрыг үндэсний үйлдвэрлэгчдэд зориулж зах зээлээс хямд үнээр түрээсэлдэг болгосон. Гэвч энд сууж байсан үйлдвэрлэгчид хямд ч гэсэн түрээсээ төлж дийлэлгүй лангуугаа сулалжээ.

Шөнийн захын хаалгаар оронгуут “Үндэсний үйлдвэрлэлээ дэмжицгээ” гэх бичигнээс өөр зүйлгүй шилэн лангуунууд нүдэнд тусна. Дотоодын үйлдвэрлэгчид өмнө нь нэг ам.метр талбайг сарын 45 мянган төгрөгөөр түрээсэлж байж. Харин өнгөрсөн сараас тус захын захиргааныхан хямралтай уялдуулан бүх лангууны түрээсээ 10 мянган төгрөгөөр хямдруулсан байна. Тус төвийн дөрөвдүгээр давхар “арай амьтай нь”. Учир нь тэнд зоогийн газар, үсчин, оёдолчин гэх мэт үйлчилгээнийхэн байрлаж.

Жилийн өмнө үндэсний үйлдвэрлэлийн бараагаар дүүрэн байсан тус захынхан иргэдийн

худалдан авах чадвар улам муудаж буйг ам уралдан ярьж байв. Улмаар орлогогүй суудаг дотоодын үйлдвэрлэгчид нэг нэгээрээ “Монголд үйлдвэрлэв” нэртэй шөнийн захыг үдсээр. Тухайлбал, энэ сард “Дархан Минж”, “Үслэг эдлэл” зэрэг томоохон үйлдвэрлэгчид лангуугаа сулалжээ. Харин одоо тэдний байсныг илтгэн шилэн лангууны ханан дээр сурталчилгааны хэдэн зураг нь л өлгөөстэй үлдэж. Тус захын 17 дугаар лангууны түрээслэгч Я.Сумъяасүрэнгийн хэлж буйгаар тэд орлого муудсан тул ийнхүү бууриа сэлгэжээ.

Харин Сумъяасүрэн цүнх, бээлий, углааш зэрэг өрхийн үйлдвэрлэлийн жижиг, сажиг бараатай. Тэрбээр хааш хаашаа гурван метр хүрэхтэй үгүйтэй талбайд сард 110 гаруй мянган төгрөг төлж сууна. Түүний худалдаалж буй гар урлалын эсгий углааш 17-22 мянган төгрөгийн үнэтэй. Харин зулхай шаахай нь 3500-10000 төгрөг байна. Тэрбээр овор багатай, олон төрлийн бараа зардаг тул ямар ч байсан түрээсээ дөнгөн данган төлж байгаа.

Шөнийн захын захиргааныхан түрээсийн үнээ бууруулсан тул дэргэдэх “Нарантуул” захаас хэд хэдэн худалдаачин Шөнийн захын шинэ өргөтгөл “Night Plaza”-руу нүүжээ.

Тэдний нэг 365 дугаар лангууны бэлэн хувцасны худалдаа эрхлэгч О.Чулуунбат захынхаас 30 мянган төгрөгөөр хямд буюу 150 мянган төгрөгийг сард төлж, дулаахан тохилог орчинд сууна. Түүний хэлснээр өнгөрсөн жилийнхээс барааны эргэлт муудсан тул худалдаачид хил дамжуулан зөөсөн бараанаасаа 5-10, ихдээ 20 мянган төгрөгийн ашиг харж байгаа аж. Барааны гүйлгээ сайн үед сард хоёр удаа бараагаа татдаг байсан бол одоо сардаа нэг удаа явахтай үгүйтэй болжээ. Чулуунбат “Би Манжуураас бараа оруулж ирдэг. Энэ хямралтай үед Эрээнээс хямд бараа дундуур нь оруулж ирэхгүй бол үнэтэй нь гүйхгүй юм” гэсэн. Тус захын түрээслэгчдийн хувьд наймаа “хагарахгүй” долоо хоног суух энүүхэнд. Харин дэргэдэх “Sunday плаза” амарсан өдөр тус зах овоо хөлтэй болдог байна.

Шинэ жилийн уур амьсгал орсон эдгээр өдрүүдэд их хотын завгүй амьдралд хямрал болон баяр дагасан хямдралууд хөвөрсөөр. Гагцхүү энэ үед мөнгөтэй нэгэн нь дэлгүүр хэсэхэд урамтай байгаа нь лавтай. ■

Шинэ жилийн ширээ ямар байх бол

Г.Орхон

Хямрал болохоор махны хэрэглээ нэмэгддэг гэдэг. Гэвч худалдан авалт муу байгааг махны худалдаачид хэлж байна. Энэ нь тус таваарын нийлүүлэлт нэмэгдсэнтэй холбоотой байж болох. Нийслэлийн томоохон хүнсний захууд дээр махны үнэ өмнөх сарынхаас нэг кг тутамдаа 200-300 төгрөгөөр буурчээ. Өнгөрсөн оны едийд “Хүчит Шонхор” зах дээр нэг кг мах 4000-9000 төгрөгийн үнэтэй байсан бол өдгөө 2000-4500 төгрөг болж хоёр дахин буурлаа. Тус зах дээр ямааны ястай махны бөөний үнэ 2000

төгрөг байгаа бол жижиглэнгийнх 2800 төгрөг байна.








“Хүчит Шонхор” захын махны худалдагч Б.Лянхуацэцэг “Махны нийлүүлэлт ихэссэн тул үнэ буурч байна. Арилжааны банкууд малчдын зээлийг хаасан тул тэд хэдэн малаа борлуулж, мөнгөтэй залгаж байгаа” гэв. Харин Бөмбөгөр худалдааны төвийн махны тасгийн худалдаачид “чанар дагасан үнийг иргэд ойлгохгүй байна” хэмээн бухимдаж сууна. Тус зах дээрх махны үнэ 4000-7000 төгрөг байна. Махны үнэ ийнхүү бодитой хямдарсан










нь инфляци эерэг харагдахад нөлөөлсөн гэж эдийн засагчид үзэж буй. Харин өргөн хэрэглээний бусад нэр төрлийн барааны ханш харьцангуй тогтвортой байна. Ер нь иргэд гурил, будаа болон махыг өдрийн хоолны хэмжээгээр худалдан авах хандлага ихэсч буйг хүнсний захын худалдаачид онцолж байна.

Уншигч танд нийслэлийн томоохон хүнсний захууд дээрх өргөн хэрэглээний барааны үнийг танилцуулъя:

МАХНЫ ҮНЭ НАВС УНАЖЭЭ

МАХ /КГ, ТӨГРӨГӨӨР/:

					
 Баянзүрх	Цул Ястай	4800 3800-4000	3500 3000	6000-6500 5000-5800	4500 4000
 Бөмбөгөр	Цул Ястай	4000-4300 4000	— —	6500-7000 5500-6000	5000 5000
 Хүчит Шонхор	Цул Ястай	3500-4000 3000	2500-3000 2000-2800	4000-5500 4000-5000	4500 4200

						
 Баянзүрх	700-800	1300-1800	1500-2000	900-1500	900-1500	1500 /боодол/
 Бөмбөгөр	700-900	1600	2000	1500	1500-2500	1800 /боодол/
 Хүчит Шонхор	600-800	1500	1500-1800	1200-1500	1000-2500	1200 /боодол/

ГУРИЛ: /КГ, ТӨГРӨГӨӨР/

	Баянзүрх	Бөмбөгөр	Хүчит-Шонхор
Улаанбаатар 10 кг /Дээд/ 25кг	13.0 30.0	13.0 29.0	13.0 30.0
Улаанбаатар 10 кг // 25кг	11.0 25.0	11.0 25.0	10.0 25.0
Алтантариа 10 кг /Дээд/ 25кг	13.0 30.0	13.0 30.0	13.0 30.0
Алтантариа 10 кг // 25кг	11.0 25.0	10.0 23.5	10.0 25.0
Хурх 25 кг /дээд/	31.0	31.0	31.0
Хурх 25 кг //	26.0	26.0	26.0
Атар 10 кг /дээд/ 25 кг	11.0 24.0	11.0 24.0	10.0 23.5
Цесна 25 кг	40.0	41.0	40.0

БУСАД /КГ, ТӨГРӨГӨӨР/

	Цагаан будаа	Элсэн чихэр
Баянзүрх	2300-3000	1500-1500
Бөмбөгөр	2100-3200	1200-1500
Хүчит Шонхор	2000	-

УРГАМЛЫН ТОС: /ТӨГРӨГӨӨР/

	Simply	Кларина	Янта
Баянзүрх	3500	3200	2800
Бөмбөгөр	3700	3200	3000
Хүчит Шонхор	3500	3200	2700

СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН /КГ, ТӨГРӨГӨӨР/

	Ааруул Чихэртэй	Ааруул Чихэргүй	Бяслаг	Аарц	Цэцгий	Шар тос Монгол	Шар тос Сингапур	Эзэгий	Өрөм /сарлагийн/
Баянзүрх	10000	10000	10000	2500	7000	10000	4000	8000	7000
Бөмбөгөр	10000	9000	9000	2500	6000	10000	4000	8000	7000
Хүчит Шонхор	8000-1000	6000-8000	9000	1800	7000-8000	8000	4000	6000-7000	6000

Эх сурвалж: Mongolian Economy

ТЕХНОЛОГИ

Төрийн үйлчилгээнд онлайн банк нэвтэрлээ

Ц.Элбэг

Өнөөгийн завгүй дэлхий ертөнцөд цаг хугацаа гэдэг алтнаас үнэтэйг улам бүр мэдрүүлж байна. Интернэт банкны үйлчилгээ Монголд төдийгүй дэлхий ертөнцөд ч тун саяхныг болтол ийм өргөн хэрэглээтэй байсангүй. Ойрын ирээдүйд онлайн банкны үйлчлүүлэгчдийн тоо эрс өсч, түүний хэрээр банкны салбарын ажилтнуудын ачаалал буурах нь маргаангүй. Энэ нь хүмүүс ихэнх цаг хугацааг онлайн өнгөрүүлж буйтай бус цаг хугацаа уюунаас ч үнэтэйг бодитой ухамсарлах болсонтой шууд холбоотой.

Монгол Улсын хувьд давхардсан тоогоор 708 мянган интернэт банкны, 1.9 сая мобайл банкны үйлчлүүлэгч байна. Өлгийтэйгээс өтгөсөө оролцуулаад гурван сая хүн амтай улсын хувьд энэ нь бага тоо биш ээ. Санхүүгийн зах зээлийн 95 хувийг банкны салбар эзлэх болсон нэг хүчин зүйл нь технологийн хөгжлийг хурдан шуурхай нэвтрүүлж буйтай ч холбоотой байж мэдэх юм. Нөгөөтэйгүүр интернэтээр банкны бараг бүх үйлчилгээг авч болж байна. Интернэтээр зөвхөн дансны үлдэгдлээ шалгах боломжтой байсан цаг саяхан. Харин өнөөдөр банк хооронд гүйлгээ хийж, бараа худалдан авч, хадгаламж нээж, зээл авч, татвараа төлж болно. Хамгийн сүүлд Худалдаа хөгжлийн банкны “Ти Ди Би онлайн” үйлчилгээ Гаалийн ерөнхий газар, Татварын ерөнхий газрын системтэй холбогдоод буй. Үр дүнд нь маш олон гадаад худалдаа хийгч иргэн, байгууллага алтан цагаа хэмнэх боломж бий болж байна. Өөрөөр хэлбэл импортоор бараа оруулж ирэхийн тулд дээрх байгууллагуудаас нэхэмжлэх бичиг авч, банкинд очин төлбөрөө төлсний дараагаар буцан татварын улсын байцаагч дээр очин төлбөр төлсөн баримтаа шалгуулсны эцэст гааль дээрээс бараагаа авдаг цаг өнгөрч байна. Энэ бүхнийг та гар утаснаасаа интернэтэд ороод эрхий хуруугаараа хэд товшоод л хэдхэн минутад (ихдээ таван минут) амжуулчихна. Үр дүнд нь та банкинд дараалалд зогсох, гааль-татварын байгууллага-банк хооронд зорчих хугацаа таны хэмнэлт юм. “Хурааснаараа бус хэмнэнсээрээ баяждаг” гэх үг бий. Магад хамгийн



үр дүнтэй хэмнэлт бол цаг хэмнэлт. Дээрээс нь, дээрх байгууллагын хооронд зорчих унааны зардал бодит хэмнэлт болж үлдэнэ.

Орчин цагийн ажил хэрэгч хүмүүсийн ойрын харилцагч нь банк. Долоо хоногтоо 2-3 удаа банкны салбар руу очих хэрэгтэй болдог завгүйчүүд нааш цааш зорчиход 15 минут, теллерээр үйлчлүүлэхэд ойролцоогоор 5-10 минут зарцуулж байгаагаар анзаарчээ. Хэрвээ энэ бүхнийг өрөөнөөсөө интернэтээр амжуулчих юм бол тухтайхан үдийн хоолондоо орж болохыг ч мөн тэд ойлгосон байна. Гэвч үнэн хэрэгтээ банкны үйлчилгээг цахимжуулах нь зөвхөн ажил хэрэгч хүмүүсийн хэрэгцээ байсангүй, банкны салбараас хол ажилладаг, гэртээ ач нараа хардаг өндөр настнуудын ч амин чухал хэрэгцээний нэг болж “онлайн банк” харилцагчдынхаа хүрээг тэлсээр байгаа билээ.

Онлайн гүйлгээнд гар утасны хэрэглээ хамгийн жинтэй. Энэ жил л гэхэд дэлхий даяар 1.1 тэрбум (урьдчилсан тооцоолол) хүн гар утаснаасаа банкны үйлчилгээг авч байна. Энэ тоо хоёрхон жилийн өмнө едөө 590 сая байсан бөгөөд энэ амжилтад 2017 онд л хүрнэ гэж тооцоолж байлаа. Гэсэн ч хөгжиж буй орнуудад нийт 2.5 тэрбум насанд хүрэгч банкны үйлчилгээ авч чадахгүй байна. Харин эсрэгээрээ эдгээр улсад мөн 2.5 тэрбум хүн гар утас хэрэглэдэг. Энэ нь онлайн банкинд ямар их ирээдүй буйг харуулж нэг тоо юм.

Монголын тухайд энэ оны эхний улиралд л гэхэд нийт 2.3 их наяд төгрөгийн гүйлгээ интернэтээр хийгджээ. Харин мобайл банкаар дамжин хийгддэг гүйлгээ нь харьцангуй бага. Нэгдүгээр улиралд 1.2 их наяд

төгрөгийн гүйлгээ мобайл банкаар хийгджээ. Энэ нь иргэд мобайл банкаар жижиг худалдан авалт хийдэг, мөн нэг удаа хийх гүйлгээний хязгаарыг ихэвчлэн багаар тогтоосон байдагтай холбоотой.

Гэхдээ энэ бүхний цаана эрсдэл байдгийг бас мартаж болохгүй. Дэлхий даяар хийгдэж байгаа нийт онлайн гүйлгээний гурван хувь орчим нь залилангийн шинж чанартай байдгийг банк, хууль хяналтын байгууллагууд анхааруулдаг юм. Үүнээс сэргийлэхийн тулд нэгдүгээрт хувь хүн өөрийн нууцлалыг сайтар хадгалах ёстой. Гар утас, таблет, компьютер гээд төрөл бүрийн интернэт дэмждэг төхөөрөмжөөс банкны үйлчилгээ авахдаа нууц кодоо сануулж үлдээхгүй, хэн нэгэнд дамжуулахгүй байх, нууц кодоо ойр ойрхон сольж, компьютер гар утсаа орхиж гарахдаа цоожилж байх зэрэг энгийн үйлдлүүд өөрийн тань санхүүгийн аюулгүй байдлыг хангахад чухал ач холбогдолтой. Түүнчлэн интернэт үйлчилгээг ашиглахад олон төрлийн нууцлал нэхдэг, шат дамжлагатай, ярьшиг төвөгтэй гэж харах нь буруу хандлага болохыг ойлгох хэрэгтэй.

Харин Монголын хувьд онлайн луйвар харьцангуй бага тохиолдол бүртгэгддэг. Арилжааны банкуудын интернэт үйлчилгээ олон улсын жишигт хүрсэн, програм хангамж өндөр хэмжээнд хөгжсөн, дотоод гадаадын томоохон банкуудтай интернэт гүйлгээ хийх боломжтой. Өнөөдөр Гаалийн ерөнхий газар, Татварын ерөнхий газар нь өөрийн төлбөр тооцооны системдээ онлайн банкны үйлчилгээг холбож байгаа нь түүний найдвартай байдлыг үнэлж буй хэрэг юм. ■

Тус сэтгүүлд байршуулсан танай компанийн сурталчилгаа лидерүүдийн ажлын ширээн дээр бүтэн жилийн туршид байх болно.



“Манай уншигчид ирээдүйн чиг хандлагын талаар чиг баримжаа, ойлголттой болох сонирхолтой байдаг, тиймээс тэд жил бүр бидний таамаглалыг тунгаан бодохын тулд эргэн ирдэг.”



Даниел Франклин
“The Economist” сэтгүүлийн эрхлэгч

Манай сэтгүүл үүсгэн байгуулагдсаны тав дахь жилийнхээ ойн үеэр Монгол дахь албан ёсны онцгой зөвшөөрөлтэйгээр The Economist сэтгүүлийн “The World in 2016” жилийн дугаарыг монгол хэлээр гаргах гэж байгаадаа баяртай байна”

Д.Бэхбаяр
“Mongolian Economy” сэтгүүлийн Эрхлэгч

Энэхүү дугаарт "The World in 2016" дугаарын дэлхийн эдийн засаг, бизнесийн хөгжлийг урьдчилан зурагласан нийтлэлүүд хэвлэгдэхээс гадна “Mongolian Economy” сэтгүүлийн зүгээс бэлтгэсэн Монгол Улсын ирэх оны эдийн засаг, улс төр, санхүү, бизнесийн салбарын хөгжлийн таамаглалыг харуулсан судалгаа–анализ бүхий нийтлэлүүд орох юм. Нийтлэлүүдийг тухайн салбарыг дүгнэж, таамаглал дэвшүүлж чаддаг нэр нөлөө бүхий хүмүүс тус сэтгүүлд зориулж бичих юм.

Утас : 94092904, 88006228, 70115476, 70115477
www.marketing@mongolianeconomy.mn
www.info@mongolianeconomy.mn

**MONGOLIAN
ECONOMY**

www.mongolianeconomy.mn



ДЭЛХИЙН ЧУУЛГАН

Уур амьсгалын өөрчлөлтийн “ЭРГЭХ ЦЭГ”

Орчуулсан Б.Энхмөнх

Уур амьсгалын өөрчлөлтийн Суурь конвенцийн 21 дэх чуулга уулзалт Парис хотноо энэ оны арваннэгдүгээр сарын 30-наас арванхоёрдугаар сарын 12-ны хооронд амжилттай болж өндөрлөлөө. Талуудын 21-р чуулганд 195 орны Засгийн газрын төлөөлөл, иргэний нийгэм, хувийн хэвшил, хэвлэлийн төлөөлөгч зэрэг нийт 50 мянга орчим төлөөлөгч оролцсон юм. Чуулганы үйл ажиллагаа, яриа

хэлэлцээ энэ сарын 11-ний өдөр дуусах байсан ч хэлэлцэгчид цогц гэрээ байгуулахыг хүсэж байсан тул нэг өдрөөр сунгасан.

Бүтэн хоёр долоо хоногийн турш эрчимтэй хэлэлцээр хийсний үр дүнд дэлхийн дулаарлын өсөлтийн хэмжээг 2 градусаас бага хэмжээнд барих гэрээнд бараг 200 гаруй улс нэгдэн батлаж чадлаа. Энэхүү гэрээ нь нүүрс хүчлийн хийг бууруулах зорилтод

дэлхийн бүх улс орнуудыг хамруулж чадсан анхны гэрээ болж байгаа юм.

Сүүлийн хэдэн жилийн турш уур амьсгалын гэрээ хийхээр Энэтхэг болон Хятад улстай нягт ажилласаар ирсэн АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Жон Керри "Манай гаригийг шинэ замналд оруулж чадахуйц гэрээнд дэлхийн нийт хүрч чадлаа" гэж хэлэв.

Хятадын талаас цаг уурын

өөрчлөлтийн хэлэлцээрт оролцсон ахлах мэргэжилтэн Си Жэнхуа "Энэхүү гэрээ төгс биш, сайжруулах шаардлагатай зарим зүйлс байгаа. Гэвч энэ нь биднийг энэхүү түүхэн замналын дагуу явахад саад болохгүй" гэж хэлжээ. Ноён Си уг гэрээг шдарга, ойлгомжтой, тэнцвэртэй, маш их амбицтай бөгөөд үр дүнтэй хэмээн тодорхойлсон юм.

Хэлэлцээрт орсон улсуудас Парисын гэрээнд хүрэхэд АНУ-ын Ерөнхийлөгч Барак Обама тус улсын нүүрсээр ажилладаг эрчим хүчний станцуудын хүлэмжийн хийн ялгаруулалтыг багасгах зорилготой АНУ-ын анхны цаг уурын өөрчлөлтийн талаарх бодлогыг баталсан нь ихээр нөлөөлсөн гэж хэлж байсан юм. Үүний зэрэгцээ, Хятад улсын агаарын бохирдлын хэмжээх сүүлийн жилүүдэд буруушаах хүмүүс олон болсонтой холбогдуулан Ерөнхийлөгч Ши Жиньпин дотоодын нүүрсний хэрэглээг багасгах бодлогыг дагах болсон билээ.

АНУ-ын Ерөнхийлөгч Барак Обама шинэхэн батлагдсан Парисын уур амьсгалын талаарх гэрээг "Эх дэлхийгээ аврах бидэнд байгаа хамгийн том боломж" хэмээн

Харин өнөөдрийн уур амьсгалын өөрчлөлтийн талаарх хувьсгал нь хамгийн гайхамшигтай бөгөөд хамгийн тайван хувьсгал боллоо" хэмээн хэлсэн юм.

Обама хэлэхдээ "Америкийн ард түмэн өөрсдөөрөө бахархаж болно. Яагаад гэвэл энэхүү түүхэн гэрээнд АНУ-ын тэргүүлэх оролцоо маш их байсан. Сүүлийн долоон жилийн туршид АНУ дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг гол тэмцэгч болж чадсан юм" гэжээ.

Арванхоёрдугаар сарын 12-ны бямба гаригийн орой дэлхийн үндэстнүүдийн баталсан уг гэрээ хамгийн том, бэрх төдийгүй зуу зуун тэрбум ам.доллар шаардах аж.

Харин жилийн турш сунжирсан энэхүү хэлэлцээрт цэг тавьснаар түүхэн дэх байгаль орчны хамгийн далайцтай хэлэлцээрт хүрч байгаа юм. Ингэснээр дэлхийн дулаарлын зөвшөөрөгдсөн хэмжээ болох 2 градус цельсийг 1.5 градус болгож уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг огцом багасгах боломжтой болж байна.

Дэлхийн дулаарлын шинэ хэмжээг тогтоох Парисын гэрээнд бусад арга хэмжээнүүд ч багтжээ. Үүнд дэлхийн

дулаарлаас үүдэлтэй бүх төрлийн асуудлуудад туслах зорилгоор мөнгөн тусламж үзүүлэх юм, учир нь далайн шуурга, үер зэрэг гамшигууд огцом нэмэгдэх болсноор зарим газар нутагт амьдрах боломжгүй болж байгаа юм.

Франц улсын Гадаад хэргийн сайд Лоран Фабиус гэрээг баталсныг зарлахад 200 гаруй орны төлөөлөгчид босч алга ташин шүгэлдэж байлаа. Лоран Фабиус энэхүү гэрээг маш ихийг зорьсон, тогтвортой гэрээ гэж хэлээд хэт дулаарсан манай гаригийг боломжит гамшигаас урьдчилан сэргийлэх зорилгод "эргэх цэг" боллоо гэж хэлжээ.

Харин ОУВС-гийн тэргүүн Кристин Лагард дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийг шийдэхэд нэг алхам урагшиллаа гэж хэлсэн бөгөөд түүний гол хэлхийг хүсэж буй санаа нь "нүүрстөрөгчийн ашиглалтад үнэ тавих юм" гэв.

Уг гэрээгээр дэлхийн улс орнууд таван жил бүр нүүрс хүчлийн ялгаруулалтаа бууруулж байх үүрэг хүлээсэн байна. Зорилтот 1.5 С-д хүрэхийн тулд цаашид хийн ялгаралтыг улам бууруулах ёстой бөгөөд Парисын гэрээг хийгдэхээс өмнө 170 гаруй орон дэлхийн дулаарлын өсөлтийг 2.7-3 градус цельсэд барих боломжтой гэж үзэж байсан юм.

Үүнээс гадна шинэ гэрээнд маш чухал урт хугацааны зорилт бий. Энэ зорилт нь энэ зууны хоёрдугаар хагас гэхэд нүүрстөрөгчийн ялгаруулалтыг бүрэн зогсоох аж. Тодруулбал, 2050 болон 2100 оны хооронд дэлхийн нүүртөрөгчийн ялгаруулалтыг тэг хэмжээнд хүргэх зорилт юм. Ингэснээр CO2-ийн ялгаруулалтыг газар дээр нь илрүүлж газар доогуурх хоолой руу ялгаруулах эсвэл илүү олон мод тарих шаардлагатай болно гэсэн үг.

Харин мэргэжилтнүүд хэлэхдээ бидний дэлхийн дулааралтай тэмцэх нэг бүлэгт цэг тавигдаж баагаа ч одоо дахин шинэ бөгөөд илүү хүнд бүлэг эхэлж байна, учир нь энэхүү өндөр зорилтот гэрээг хэрэгжүүлэхэд маш их зүйлийг давж гарах хэрэгтэй болно гэжээ.

Хэдийгээр 1.5 градус цельсэд хүргэх уг гэрээг олон нийт маш их дэмжиж байгаа ч эрдэмтэд үүнийг хэрэгжүүлж ажил болгож чадах эсэхд эргэлзэж байгаа юм. Өнгөрсөн сард шинэ судалгаагаар дэлхий үйлдвэрлэлийн өмнөх үеэс 1 градус цельсээр дулаарсан нь тогтоогдсон бөгөөд энэ нь бидэнд цаг маш бага байгааг илтгэж байна. ■



сайшаажээ. Тэрээр хэлэхдээ уг гэрээ дэлхийн хувьд эргэх цэг мөн түүний засгийн газрын хувьд тодорхойлох мөч байж болох юм гэж уг түүхэн гэрээнд хүрсний дараагаар мэдэгдсэн аж.

Францын Ерөнхийлөгч Франсуа Олланд "Зуун зууны туршид Парист маш олон хувьсгал гарч байсан.

хамгийн баян орнууд 2020 оноос эхлэн хөгжиж буй орнуудад үер, ган, шуурга гэх мэт уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэх гамшигаас урьдчилан сэргийлэхэд туслах зорилготой дор хаяж 100 тэрбум ам.долларыг зарцуулна гэсэн амлалт өгсөн байна. Мөн буурай орнуудад дэлхийн

Шинжааны хүчирхийлэл: Хятад улсад терроризмын асуудал бий юу

Б.Энхмөнх

Хятадын төрийн хэвлэл мэдээллийн албаны мэдээлж буйгаар өнгөрсөн сард тус улсын хагас цэрэгжүүлсэн цагдаагийн хэсгийнхэн есдүгээр сард болсон нүүрсний уурхайд болсон цуст халдлагыг үйлдсэн байх магадлалтай 28 сэжигтнийг агуй дотор шатаан хороожээ. Эдгээр үйл явдлууд бүгд Хятадын баруун хэсэгт орших олон үндэстнүүдэд хуваагдсан, Байгалийн нөөцөөр баялаг Шинжаанд болж өрнөсөн юм. Тус бүс нутагт муслим шашинтай Уйгур үндэстнүүд голдуу оршдог аж.

Хятадын засгийн газар уг халдлагыг Уйгурын салан тусгаарлагчид үйлдсэн хэмээн буруутгаж байгаа бөгөөд тэднийг Исламын улс болон Аль Кайдагийн алан хядагчдаас өөрцгүй гэж үзэж байгаа аж. Харин тус үндэстний хэсэг бүлэг болон хүний эрхийн төлөө тэмцэгчид хэт захирангуй шашны бодлого болон эдийн засгийн тусгаарлалт тэднийг ийн өдөөхөд хүргэж байна гэж үзэж байгаа юм.

Бээжин Хятад улсыг бусад террорист халдлагад өртөж буй орнуудтай адилаар авч хэлэлцэхгүй гадуурхагдаж байна хэмээн гомдоллож байгаа аж. Арванхоёрдугаар сарын 2-ны Лхагва гаригт, БНХАУ-ын Гадаад хэргийн яамны төлөөлөгч Хуа Чуньин "Яагаад бусад улсад гарч буй халдлага терроризмд тооцогдож харин манайд болж байгааг үндэстэн угсаатан ба шашны асуудал гэж үзэж байгааг ойлгохгүй байна" гэв.

"Яагаад бусад улс терроризмын эсрэг арга хэмжээ авахад үндэслэлтэй хэмээн үзэж, харин Хятадыг эсрэг арга хэмжээ авахад үндэстэн ястны хавчин гадуурхалт, дарангуйлал хийлээ гэж

үзэж байгааг ойлгохгүй байна" гэж тэрбээр нэмж хэлжээ.

Тэхээр яг юу болоод байна вэ, асуудлын гол үндсэн шалтгаан юу вэ?

СҮҮЛД БОЛСОН ХАЛДЛАГААР ЮУ БОЛСОН БЭ?

Олон янзын мэдээлэл гарсан ба мэдээллүүд хоорондоо зөрчилдөж байна.

Аксу хотын нүүрсний уурхайд хутга ашиглан халдлага хийжээ гэсэн мэдээг анх АНУ-аас санхүүждэг Уйгур хэл дээр нэвтрүүлэг бэлтгэдэг "Radio Free Asia" радио мэдээлсэн юм. Тус радиогоор мэдээлэхдээ есдүгээр сарын 18-нд 50 хүн амиа алдаж, мөн 50-иас илүү хүн гэмтэж бэртсэн гэжээ.

"Radio Free Asia"-ийн мэдээлж буйгаар тус уурхайд голдуу Хятадын Хан үндэстнүүд ажилладаг бөгөөд амь үрэгдсэн хүмүүсийн дийлэнх нь тус үндэстнүүд байсан гэж байгаа юм.

Харин Хятадын төрийн хэвлэл мэдээллийн алба уг хэрэг болсныг арваннэгдүгээр сарын 20-нд хүлээн зөвшөөрчээ. Шинжаан мужын засаг захиргааны Тианшан вэб хуудаст бүлэг хүмүүс уурхайд халдлага хийх үеэр 16 хүн, үүн дотор таван цагдаа амь үрэгдэж, 18 хүн шархадсан гэж мэдээлсэн юм.

Тус мэдээллийн албаны хийсэн мэдэгдлээр 56 хоног эрэн сурвалжилсаны эцэст арваннэгдүгээр сарын 12-нд халдлага үйлдэгчдийг агуй дотор бүгэж буйг нь илрүүлсэн гэжээ. Цэргүүд халдлага үйлдэгчдийг агуйгаас гаргахын тулд нулимс асгаруулагч болон хийн гар бөмбөг ашигласан ч амжилтгүй болсны улмаас гал шүршигч ашигласан аж.

Албан бүртгэлд ойролцоогоор 28



хүн агуйгаас зугтан гарч байхдаа амь үрэгдэж нэг хүн бууж өгсөн гэжээ. Харин "Radio Free Asia"-ийн мэдээлж буйгаар уг ажиллагааны явцад 17 хүн амь үрэгдсэнээс долоо нь эмэгтэйчүүд болон хүүхдүүд байсан гэсэн юм. "CNN" агентлаг Шинжааны засаг захиргааны хэвлэлийн төлөөлөгчөөс тодруулга авах гэсэн ч тэд хариулахаас татгалзсан гэв.

УЙГУРТ ТЕРРОРИСТ БҮЛЭГЛЭЛ БАЙДАГ УУ?

Парисын халдлага гарснаас хойш Хятад улс дэлхий нийтийг Шинжаанд болж буй терроризмын эсрэг тэдний хүчин чармайлтыг дэмжихийг уриалсан юм. Ройтерс агентлагын мэдээлснээр, БНХАУ-ын Гадаад хэргийн сайд Ван И "Хятад улс мөн л терроризмын хохирогч, Зүүн Туркестаны Исламын Хөдөлгөөний эсрэг арга хэмжээ нь олон улсын терроризмын эсрэг тэмцэлийн чухал хэсэг болох ёстой" гэж хэлжээ. Бээжин Хятадад болж буй хүчирхийлэлд Зүүн Туркестаны Исламын хөдөлгөөнөөр



тэргүүлүүлсэн Исламын зэвсэгт бүлэглэлийг буруутгаж байгаа бөгөөд АНУ-ын Төрийн департамент тус хөдөлгөөнийг есдүгээр сарын 11-ний халдлагаас нэг жилийн дараагаар буюу 2002 онд террорист байгууллагын жагсаалтад оруулсан юм. Гэвч тус хөдөлгөөнийг Исламын улс болон Аль Кайдатай адилтгах нь тохиромжгүй гэж маргадаг олон шинжээчид бий. Тэдний үзэж буйгаар Шинжанд өрнөж буй иргэний үймээнийг зохион байгуулалттай зэвсэгт бүлэглэл гэхээс илүүтэй хувь хүн эсвэл хэсэг бүлэг цөөн тооны хүмүүс үйлдэж байгаа хэмээн үзэж байгаа аж. БНХАУ-ын Засгийн газар тус бүс нутагт нэвтрэгчдийг нягт хянадаг аж. Тэр дундаа тус бүс нутагт нэвтрэсэн сэтгүүлчдийг сайтар ажигладаг бөгөөд заримдаа тэднийг зарим бүсэд нэвтрэхийг бүрэн хориглодог аж. Төрийн бус байгууллагуудыг ч мөн адил хянадаг байна. "Хүн ам руугаа чиглэсэн хүчирхийлэл үргэлж уй гашуу дагуулсаар ирсэн, гэсэн хэдий ч энэ нь Засгийн газрын үйлдлийг

мужуудад маш олон халдлага болсон хэмээн буруутгаж байгаа аж. 2014 онд Хятадын өмнөд хэсэгт орших Кунминг хотод 31 хүн төмөр замын буудал дээр хутгалуулж амиа алдсан. 2013 онд Тяньаньмэний талбайн гадна байсан жуулчид руу машинаар дайрч таван хүн нас барсан.

Хятадын төрийн мэдлийн "Глобал Таймс" сонин 2014 онд Хятадын 300 иргэн Исламын улстай хамт Иран болон Сирид дайтаж байгаа бөгөөд эдгээр зэвсэгт этгээдүүд эргэн ирж үндэсний аюулгүй байдалд заналхийлэх вий гэхээс эмээж байна гэж мэдэгдэж байжээ. Шинжаан нь Хятадын хамгийн их байгалийн баялаг ихтэй мужуудын нэг бөгөөд томоохон нүүрс, байгалийн хий болон ховор металлын ордтой юм.

Тус бүс нутаг Ерөнхийлөгч Си Зянь Пинээр тэргүүлүүлсэн "Нэг бүс, нэг зам" санаачлагад голлох үүрэг гүйцэтгэж байгаа бөгөөд тус санаачлагаар Төв Азийн эдийн засгийн холбоог сайжруулах зорилготой юм.

хаацаалж чадахгүй. Хятадын терроризмын эсрэг кампанит ажлын үр дүнд амь үрэгдэгсдийн тоо Бээжингийн тактик болон зорилтын эргэлзээг улам гүнзгийрүүлж байна" хэмээн "Human Rights Watch" хүний эрхийн төлөөх төрийн бус байгууллагын Хятад дахь дарга Софи Ричардсон хэлсэн юм.

Тэрбээр "Хятад улс үнэхээр л нуух зүйлгүй бол НҮБ-ийн мэргэжилтнүүд, хараат бус сэтгүүлчид, дипломатчид болон бусад ажиглагчдыг тус бүс нутагт чөлөөтэй нэвтэрч энэ хэргийг судлах эрхийг олгох цаг аль хэдийн болсон" гэж нэмж хэлжээ.

ХЯТАД УЛС ЮУНААС ЭМЭЭЖ БАЙНА ВЭ?

Сүүлийн жилүүдэд олон зуун хүн Шинжанд амь насаа алдсан бөгөөд Хятадын эрх баригчид тус мужаас гадна өөр

УЙГУРЧУУД ГЭЖ ХЭН БЭ?

Шинжаан муж нь Монгол, ОХУ, Казахстан, Киргизстан, Тажикистан, Афганистан, Пакистан болон Энэтхэг улстай хиллэдэг бөгөөд уйгурчууд Турк хэлтэй ойролцоо хэлээр ярьдаг төдийгүй Хятадын ноёрхол дор байсан олон жилийн түүхтэй боловч өөрсдийгөө соёл ба үндэстний хувьд Төв Азитай илүү ойр гэж үздэг.

Сүүлийн 60 жилийн туршид Хятадын зонхилох үндэстэн болох Хан үндэстэн Шинжаан муж руу ихээр нүүн суурьших болсны улмаас Хан болон Уйгур үндэстний хооронд зөрчилдөөн үүсч эхэлсэн юм. Өнөөдөр Шинжаанд 10 сая Уйгур үндэстэн амьдардаг бол Хан үндэстний хувьд ойролцоогоор найман сая амьдардаг аж, энэ тоо 1949 онд дөнгөж 220.000 байжээ. Шинээр суурьшигчид дийлэнх шинэ ажлын байрыг өөрсдийн болгож авч байгаа бөгөөд Уйгурчуудын дунд ажилгүйдлийн түвшин өндөр байна. Хэдий эрх баригчид тэгш эрх, үндэстнүүдийн эв нэгдлийг амладаг ч Уйгурчууд аюулгүй байдлын албаныхан тэднийг ялгаварлан гадуурхдаг хэмээн гомдоллодог. Уйгурын цөллөгсөд болон хүний эрхийн төлөө тэмцэгчид хэлэхдээ шашныг дарангуйлах бодлого болон эдийн засгийн тусгаарлагдмал байдал сүүлийн үед болж буй эмх замбараагүй байдлыг өдөөж байна гэж буй. Мөн тэд Уйгур хэлийг боловсролын системд хангалтгүй ашигладаг гэж байгаа аж.

Хятадын засгийн газар Шинжаанд Муслимчуудыг Рамаданы ёслол үйлдэж тэр байтугай харж үзэхийг хориглох илэрхий хүчин чармайлт гаргаж байгааг олон улс шүүмжилж байгаа юм. Нэг хотод долоо хоног үргэлжлэх спортын арга хэмжээний үеэр сахалтай эрчүүд болон гэвлүүр өмссөн эмэгтэйчүүдийг нийтийн тээврээр зорчихыг хориглож байсан тохиолдол ч байна. "Уйгарчууд өөрсдийн хэлийг боловсролын салбарт ашиглаж буй байдал, шашин шүтэх эрх чөлөө, өөрсдийн үндэстний нэгээхэн хэсэг болох хувцаслалт, сүмд залбирах эрх болон Рамаданыг үзэж сонирхох эрхдээ санаа зовниж байна" хэмээгээд Австралийн "La Trobe" их сургуулийн багш Хятадын үндэстний бодлогыг судлаач Жэймс Лейболд хэлсэн юм. ■